

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

МОНГОЛ УЛСЫН ОУИТБС-ЫН 7 ДАХЬ УДААГИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАН - 2012



2013 оны 12 дугаар сар

MOORE STEPHENS



DALAI VAN AUDIT

Энэхүү баримт бичгийг Англи хэл дээрх эх баримтаас нь орчуулсан бөгөөд зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор орчуулсан болно. Энэхүү орчуулга болон Англи эхийн хооронд ямар нэгэн зөрүү гарах тохиолдолд Англи хэлээрх эх баримтыг даган мөрдөнө.

АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	6
Нэгтгэлийн үр дүнд илрүүлсэн үндсэн асуудлууд	6
1. ТАНИЛЦУУЛГА	12
1.1 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)	12
1.2 ОУИТБС Монгол улсад	12
1.3 Монгол улс дахь олборлох салбарын нөхцөл байдал	13
2. ЗОРИЛТУУД, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАНДЛАГА БОЛОН АРГА ЗҮЙ	20
2.1 Зорилтууд	20
2.2 Хандлага болон арга зүй	20
3. АУДИТЫН НЭГТГЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	25
3.1 ОУИТБС-д хамрагдах олборлох үйлдвэрлэлийн компаниуд	25
3.2 ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан төрийн байгууллагууд	25
3.3 ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан төлбөрийн төрөл	26
3.4 Тайлангийн маягтууд	32
4. НЭГТГЭЛ АЖЛЫН ҮР ДҮНГҮҮД	34
4.1 Уул уурхайн компанийн нэгтгэл	34
4.2 Татварын орлогын урсгалын нэгтгэл	41
4.3 Тохируулгууд	44
4.4 Нэг талаас тайлагнасан төлбөрүүд	58
5. ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД	61
5.1 Уул уурхайн компаниудын шийдэгдээгүй зөрүү	61
5.2 Шийдэгдээгүй үлдсэн зөрүүний төлбөрийн урсгал	65
6. ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ТООНУУДЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	68
6.1 2012 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайланд тусгагдсан уул уурхайн компаниудын төлбөр	68
6.2 2012 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайланд тусгагдсан татварын төрөл	68
6.3 2012 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайланд тусгагдсан уул уурхайн үйл ажиллагааны төрөл	69
6.4 Орон нутгийн төсвийн төлбөрийн шинжилгээ	69
6.5 Орон нутагт өгсөн хандив, дэмжлэгийн шинжилгээ	69
7. БУСАД НЭМЭЛТ АЖЛУУД	70
7.1 Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа	70
7.2 Нөхөн сэргээлтийн судалгаа	73
7.3 Орон нутагтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн судалгаа	81
8. ЗӨВЛӨМЖҮҮД	82

ХАВСРАЛТ	90
Хавсралт 1: Шийдэгдээгүй эцсийн зөрүү.....	91
Хавсралт 2: 2012 оны Ил Тод Байдлын Санаачилгын тайланд хамрагдсан компаниудын жагсаалт	95
Хавсралт 3: Уул уурхайн компаниудын тайлагнасан бүтээгдэхүүний мэдээ	102
Хавсралт 4: Уул уурхайн компанийн лицензийн задаргаа.....	109
Хавсралт 5: Уул уурхайн компаниудын аудит, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хэрэгжилт	130
Хавсралт 6: Орон нутгийн төсөв төлсөн татвар, төлбөр, хураамжийн дэлгэрэнгүй	136
Хавсралт 7: Орон нутагт өгсөн хандив, дэмжлэгийн дэргэлэнгүй	137
Хавсралт 8: Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	138
Хавсралт 9: Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа.....	143
Хавсралт 10: Уул уурхайн компаниудын орон нутгийн ЗДТГ-тай хийсэн гэрээнүүдийг аудитад хамруулсан байдал.....	146
Хавсралт 11: Орон нутгийн ЗДТГ-тай байгуулсан гэрээний судалгаа.....	150
Хавсралт 12: Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн уул уурхайн компаниудын албан тушаалтан	161
Хавсралт 13: Нэгтгэлийн ажилд мэдээлэл өгсөн Засгийн газрын байгууллагуудын албан тушаалтан	169
Хавсралт 14: Нэгтгэлийн баг	171

ТОВЧИЛСОН ҮГСҮЙН ЖАГСААЛТ

₮ эсвэл Т	Төрөг
АМГ	Ашигт малтмалын газар
АХ	Олон талын оролцоот Ажлын хэсэг
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
Га	Га
ГТГ	Газрын тосны газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
кв /км	Квадрат километр
МБ	Монгол Банк
НӨАТ	Нэмэгдэл өртгийн албан татвар
ОУАС	Олон улсын аудитын стандарт
ОУНББС	Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ОУНБХ	Олон улсын нягтлан бодогчдын холбоо
ОУТСНББС	Олон улсын төрийн салбарын нягтлан бодох бүртгэлийн стандарт
СЯ	Сангийн яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Анхаар: Энэхүү баримт бичгийг ашиглахад хялбар болгох үүднээс компаниудыг 1- 200 хүртэл дугаарласан болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

2012 оны 1 дүгээр сарын 1-нээс 2012 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд буюу 2012 оны санхүүгийн жилд хийгдсэн газрын тос болон ашигт малтмалын хайгуул, олборлолттой холбоотой мөнгөн болон мөнгөн бус татвар, төлбөр, хураамжийн урсгалын аудитын нэгтгэлийг Мур Степенс болон Далайван аудит компанийн хамтарсан консорциум 2013 оны 7 дугаар сарын 29-нөөс 11 дүгээр сарын 19-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

Энэхүү аудитын нэгтгэлийн үйл ажиллагааг Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс баталж, талуудын хооронд гэрээнд хавсралт болгон оруулсан Гүйцэтгэх ажлын даалгаварт заасны дагуу хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэх ажлын хугацаа, нөхцлүүд болон нэгтгэлийн хамрах хүрээг Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа баталсан юм.

Аудитын нэгтгэлийн үйл ажиллагааны нийтлэг зорилт нь Монгол улсын Засгийн Газар болон хамаарах бусад оролцогч талуудад олборлох салбарын зүгээс тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг ойлгоход туслах, олборлох үйлдвэрлэлийн салбарын хариуцлага, ил тод байдлыг сайжруулахад чиглэж байна.

Нэгтгэлийн үр дүнд илрүүлсэн үндсэн асуудлууд

Энэхүү нэгтгэлийн үйл ажиллагааны гол олж илрүүлсэн асуудлуудад доорх зүйлүүд багтаж байна:

- 2012 оны аудитын нэгтгэлд хамруулахаар нийт 200 компанийг сонгон авсан байна. Эдгээр компаниас Доншен Петролеум ХХК-иас бусад нь ОУИТБС-ын тайлангаа гарган өгсөн байна. Гэсэн ч гарган өгсөн тайланд тухайн тайлагнасан төлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсарган ирүүлээгүй, зөвхөн татварын төрөл нэг бүрээр мөнгөн дүнг нэгтгэн тайлагнасан байна. Нэгтгэлийн ажлын хүрээнд бүх компанитай холбогдож ажилласан. Энэхүү нөхцөл байдал нь аудитын нэгтгэлийн ажлыг цаг хугацаанд нь дуусгах болон тайланг бэлтгэх үйл явцыг удаашруулсан.
- Өөрийн тайландаа дурдсан мэдээллийнх нь талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор холбоо тогтоон хамтран ажилласан компаниудын дундаас доор дурдсан компаниуд дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөөгүй. Үүний улмаас бид эдгээр компани дээр гарсан зөрүүг шалган, тохируулга хийх боломжгүй байсан болно.

№	Компани
54	Дархан Бор Хужир ХХК
82	Мандал Алтай Групп ХХК
87	Монгол Алтай Ресурсис ХХК
90	МонголБолгарГео ХХК
98	НАБД ХХК
99	Нарантуул Трейд ХХК
114	Петро Чайна Дачин Тамсаг ХХК

- Нэгтгэлд хамруулахаар тогтсон компаниудын дундаас долоон компани тусгай зөвшөөрөл эзэмшдэг боловч олборлох үйл ажиллагааг явуулдаггүй болох нь тогтоогдсон. Эдгээр компаниас хүлээн авсан төлбөр дээр зөвхөн олборлох салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор төлсөн татвар, төлбөр, хураамж дээр тохируулга хийгдсэн.

№	Компани
26	Билгүүнтрейд ХХК
30	Бридж Констракшн ХХК
81	Макс Импекс ХХК

№	Компани
107	Орчлон Констракшн ХХК
130	Таван толгой транс ХХК
150	Хера Инвестмент ХХК
199	ЭСТО ХХК

- Төрийн байгууллагуудын тайланг ТЕГ цуглуулан авч, нэгтгэн тайлагнасан байна. Нэгтгэлийн үйл ажиллагааг явуулсан аудиторт тухайн жилд олборлох үйлдвэрлэлийн компаниудаас хүлээн авсан хамаарах нийт дүнг Эксел програмын ажлын хуудсан дээр тайлагнасан байлаа. Энэхүү нэгтгэсэн ажлын хуудас нь тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 1,829 компаниас хүлээн авсан төлбөрийг жагсаан гаргасан байв. Харин компаниудын тайлагналын хувьд Засгийн газрын хүлээн авсан болохыг батлах төлбөр бүрийн нарийвчилсан мэдээлэл байхгүй байв. Аудиторууд нь хамаарах төрийн байгууллагад хандан эдгээр төлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргуулан авах хүсэлтийг гаргасан.
- Хамрагдсан компаниудын зөвхөн нэг нь л (Резервоир Монгол ХХК) хөндлөнгийн аудиторын баталгаажуулсан тайланг гарган өгсөн байна. Ажлын хэсгийн зүгээс компани болон төрийн байгууллагуудаас хүлээн авч буй мэдээллийн найдвартай, үнэн зөв байдлыг баталгаажуулахтай холбоотой (ОУИТБС-ын дүрмийн 12 болон 13-д заасны дагуу) ямар нэгэн тодорхой процедурыг гаргаагүй байна.
- Нийт 47 төлбөрийн урсгал буюу төрлийг “үндсэн төлбөр” хэмээх ангилалд багтаан, энэхүү тайланд нэгтгэн оруулсан. Бусад 23 төрлийг “сайн дурын” хэмээх ангилалд хамааруулан энэхүү тайланд зөвхөн нэг талын мэдээллийг үндэслэн тохируулга хийж тусгасан.
- Олборлох үйлдвэрлэлийн компаниудын тайлагнасан нийт төлбөр болон төрийн байгууллагуудын тайлагнасан нийт хүлээн авсан төлбөрийн (**Үндсэн төлбөр**) хоорондын цэвэр зөрүү нь анхны нэгтгэлээр 150,374,210 мянган төгрөг буюу Засгийн газрын зүгээс тайлагнасан дүнгийн **10%**-тай тэнцэх хэмжээнд байсан:

	Компаниуд (1000 ₮)	Засгийн газар (1000 ₮)	Зөрүү (1000 ₮)	%
Тайлагнасан нийт Үндсэн төлбөр	1,651,425,548	1,501,051,338	150,374,210	10%

- Нэгтгэл ажил дуусах үед үлдэх нийт зөрүүний хэмжээ нь **360,966 мянган төгрөг** буюу Засгийн газрын зүгээс тайлагнасан үндсэн төлбөрийн дүнгийн **0.02%**-тай тэнцэх хэмжээнд хүрч буурсан:

	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)	%
Нийт тайлагнасан үндсэн төлбөрүүд	1,594,114,641	1,593,753,675	360,966	0.02%

Тохируулга хийгдсэний дараах **360,966** мянган төгрөг зөрүү нь **2,483,618 мянган төгрөгийн** нийт эерэг зөрүү, **(2,122,652) мянган төгрөгийн** сөрөг зөрүүнээс гарсан бөгөөд энэ талаар тайлангийн 5 дугаар хэсэгт дурдсан.

Тайлан гаргагч байгууллагуудын тайлагнасан анхны мөнгөн дүнд хийгдсэн тохируулгын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон тодруулга хийгдээгүй үлдсэн зөрүүний талаарх мэдээллийг энэхүү тайлангийн Хэсэг 4.3 болон 5 дээр тусгасан.

9. Бид доор дурдсан хүснэгт дээр нэгтгэлийн ажлын дараагаар нийт тайлагнасан мөнгөн дүн нь ихээхэн өндөр ач холбогдол бүхий компаниудын талаарх тоймыг тусган харууллаа. Засгийн газрын зүгээс хүлээн авсан хэмээн тайлагнасан дүн нь компаниудын зүгээс төлсөн хэмээн тайлагнасан мөнгөн дүнгээс 360,966 мянган төгрөгөөр доогуур байна.

№	Компани нэр	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)
196	Эрдэнэт үйлдвэр ХХК	519,761,765	519,726,775	34,990
110	Оюу толгой ХХК	201,967,916	201,918,246	49,670
190	Энержиресурс ХХК	111,921,183	111,928,313	(7,130)
114	Петрочайна дачин тамсаг ХХК	105,656,807	104,864,082	792,725
93	Монголын Алт МАК ХХК	86,161,824	86,103,290	58,534
194	Эрдэнэс МГЛ ХХК	80,141,426	80,142,183	(757)
131	Тавантолгой ХК	57,922,095	58,485,547	(563,452)
195	Эрдэнэс Таван толгой ХК	41,393,366	41,392,755	611
28	Болдтөмөр Ерөө гол ХХК	37,918,359	37,908,463	9,896
122	Саусгоби сэндс ХХК	37,715,486	37,715,532	(46)
29	Бороогоулд ХХК	33,669,722	33,478,789	190,933
80	Магнай трейд ХХК	30,214,617	30,217,564	(2,947)
159	Цайртминерал ХХК	25,342,018	25,305,957	36,061
7	Алтайн хүдэр ХХК	22,754,141	22,428,073	326,068
167	Чинхуа МАК нарийн сухайт ХХК	20,232,658	20,233,500	(842)
55	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	13,281,228	13,281,228	-
91	Монголросцветмет ХХК	12,108,432	12,047,525	60,907
8	Алтан дорнод монгол ХХК	9,762,567	9,762,567	-
15	Багануур ХК	8,430,402	8,430,470	(68)
174	Шинь шинь ХХК	7,544,787	7,544,787	-
58	Доншен Петролиум ХХК	-	633,174	(633,174)
	Бусад	130,213,842	130,204,855	8,987
Нийт Үндсэн төлбөр		1,594,114,641	1,593,753,675	360,966

10. Доор буй хүснэгт дээр бид нэгтгэлийн ажлын дараагаар тодорхой болсон хамгийн чухал гэж болох зөрүүний талаарх тойм мэдээллийг харууллаа:

№	Компани нэр	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)
114	Петрочайна дачин тамсаг ХХК	105,656,807	104,864,082	792,725
7	Алтайн хүдэр ХХК	22,754,141	22,428,073	326,068
54	Дархан борхужир ХХК	281,398	82,012	199,386
29	Бороогоулд ХХК	33,669,722	33,478,789	190,933
51	Голден сий петролиум ХХК	1,309,534	1,194,612	114,922
91	Монголросцветмет ХХК	12,108,432	12,047,525	60,907
93	Монголын Алт МАК ХХК	86,161,824	86,103,290	58,534
18	Баялаг-Орд ХХК	213,455	158,512	54,943
104	Олон овоот гоулд ХХК	4,198,883	4,144,830	54,053
88	Монгол Газар ХХК	480,411	428,507	51,904
110	Оюу толгой ХХК	201,967,916	201,918,246	49,670
66	Жөн Юан ХХК	286,900	243,478	43,422
90	Монголболгаргео ХХК	403,131	359,975	43,156
159	Цайртминерал ХХК	25,342,018	25,305,957	36,061
37	Бэрх ресорсиз ХХК	344,176	309,059	35,117
196	Эрдэнэт үйлдвэр ХХК	519,761,765	519,726,775	34,990

№	Компани нэр	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)
23	Би Ди Би Эл ХХК	154,430	124,648	29,782
102	Одод Гоулд ХХК	659,919	634,558	25,361
94	Мондулаан трейд ХХК	4,496,303	4,472,341	23,962
2	АГМ майнинг ХХК	259,972	307,972	(48,000)
20	Баян-Айраг Эксплорэйшн ХХК	2,375,038	2,475,423	(100,385)
124	Си өү эй эл ХХК	3,621,183	4,135,774	(514,591)
131	Тавантолгой ХК	57,922,095	58,485,547	(563,452)
58	Доншен Петролиум ХХК	-	633,174	(633,174)
	Бусад	509,685,188	509,690,516	(5,328)
	Нийт Үндсэн төлбөр	1,594,114,641	1,593,753,675	360,966

Бүх компаниар тэдний тайлагнасан бүх төлбөрийг тусгасан бүрэн хэмжээний хүснэгтийг Хавсралт 1 дээр харуулсан.

11. Доор дурдсан хүснэгт дээр үндсэн төлбөрүүдийн төрөл бүрээр нь нэгтгэлийн төгсгөл үеийн байдлыг, үүнээс гарсан үр дүнг харууллаа.

№	Орлогын урсгал төрөл	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)
А- Үндсэн төлбөрүүд				
	1. Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг	1,486,754,662	1,488,199,725	(1,445,063)
1.1.1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	192,277,422	192,321,230	(43,808)
1.1.2	Гаалийн албан татвар	60,334,711	60,187,994	146,717
1.1.3	Нэмэгдсэн өртгийн албан татвар	219,322,675	219,179,003	143,672
1.1.4	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	2,685,092	2,874,898	(189,806)
1.1.5	Автобензин, дизелийн түлшний албан татвар	1,847,195	1,872,582	(25,387)
1.2.1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	510,415,045	510,410,648	4,397
1.2.2	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	19,335,461	19,358,456	(22,995)
1.2.3	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	1,493,814	1,493,149	665
1.2.4	Гадаадын мэргэжилтэн, ажилчны байрны төлбөр	10,369,224	10,493,841	(124,617)
1.2.5	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд гарын үсэг зурсны урамшуулал	487,615	487,498	117
1.2.6	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	-	-	-
1.2.7	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төвлөрүүлсэн сургалтын урамшуулал	860,511	860,424	87
1.2.8	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төвлөрүүлсэн талбайн дэнчин	663,108	663,045	63
1.2.9	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төвлөрүүлсэн захиргааны үйлчилгээний шимтгэл	139,524	139,524	-
1.2.10	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	860,939	862,521	(1,582)
1.2.11	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	22,396,070	22,395,249	821
1.2.12	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	102,055,868	102,316,584	(260,716)
1.3.1	Гаалийн үйлчилгээний хураамж	33,079,155	34,141,856	(1,062,701)
1.4.1	Төрийн өмчийн ногдол ашиг	114,621,665	114,621,665	-
1.5.1	Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	80,000,000	80,000,000	-
1.5.2	Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт ногдох орлого	-	-	-

№	Орлогын урсгал төрөл	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)
1.5.3	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	100,885,111	100,885,111	-
1.5.4	Үүнээс: байгалийн нөөц ашигласны төлбөр	303,800	303,800	-
1.6.1	Торгууль	8,179,509	8,176,562	2,947
1.6.2	Нөхөн төлбөр	4,072,361	4,085,590	(13,229)
1.6.3	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	68,495	68,495	-
1.6.4	Бусад	292	-	292
2. Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг		92,841,103	92,442,598	398,505
2.1.1	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,438,576	4,492,782	(54,206)
2.1.2	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,128,422	1,170,770	(42,348)
2.2.1	Газрын төлбөр	11,866,412	11,843,466	22,946
2.2.2	Ус ашигласны төлбөр	8,790,817	8,766,393	24,424
2.2.3	Түгээмэл тархацтай ашигт, малтмалын нөөц ашигласны төлбөр	3,748,532	3,492,493	256,039
2.2.4	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	3,338,929	3,293,039	45,890
2.2.5	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан дэмжлэг	146,891	131,579	15,312
2.4.1	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	33,001,792	33,000,000	1,792
2.5.1	Торгууль	15,333,309	15,283,885	49,424
2.5.2	Нөхөн төлбөр	1,134,150	1,134,150	-
2.5.3	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг дансанд төвлөрүүлсэн дүн	2,506,695	2,396,551	110,144
2.5.4	Бусад	7,406,578	7,437,490	(30,912)
3. Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг		14,518,876	13,111,352	1,407,524
3.1	Яам, агентлагийн авсан мөнгөн хандив, дэмжлэг	5,697,959	5,663,581	34,378
3.2	Яам, агентлагийн авсан мөнгөн бус хандив, дэмжлэг	219,988	-	219,988
3.3	Аймаг, нийслэлийн авсан мөнгөн хандив дэмжлэг	1,998,416	1,988,132	10,284
3.4	Аймаг, нийслэлийн авсан мөнгөн бус хандив дэмжлэг	719,272	39,296	679,976
3.5	Сум, дүүргийн авсан мөнгөн хандив, дэмжлэг	2,170,626	2,169,272	1,354
3.6	Сум, дүүргийн авсан мөнгөн бус хандив, дэмжлэг	3,409,977	3,149,154	260,823
3.7	Бусад байгууллагын авсан мөнгөн хандив, дэмжлэг	295,741	95,080	200,661
3.8	Бусад байгууллагын авсан мөнгөн бус хандив, дэмжлэг	6,897	6,837	60
Нийт Үндсэн төлбөр		1,594,114,641	1,593,753,675	360,966

12. Шийдэгдээгүй үлдсэн **360,966** мянган төгрөгийг доорх байдлаар задлан харуулж болно:

	Дүн (Мянган төгрөг)
Компани тайлан мэдээ ирүүлээгүй	(633,174)
Засгийн газраас ирсэн баримт нь тайлантай тохирохгүй	(631)
Компани дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй	913,750
Засгийн газар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй	6,484
Компани төлсөн татвараа тайлагнаагүй	(1,869,410)
Засгийн газар хүлээн авсан татвараа тайлагнаагүй	2,191,237
Дэлгэрэнгүй мэдээлэл ирсэн боловч ашиглах боломжгүй, ойлгомжгүй	(248,146)
Ханшийн зөрүү	1,340
Материаллаг бус дүн <MNT 100K	(484)
Нийт дүн	360,966

Хүлээн авсан тайлангийн маягт дээрээс үүдсэн зөрүүг Бүлэг 5 дээр дэлгэрэнгүй харуулсан.

13. Тайлангийн маягтууд дээр буй “сайн дурын мэдээлэл” (Тайлангийн 3.3.2-ыг үзнэ үү) хэмээх ангиллын хүрээнд тайлан гаргагч аж ахуйн нэгжүүд нь хамаарах тайлангаа гарган өгсөн. Эдгээр төлбөрүүд зөвхөн нэг талын тайлан дээр тусгагдсан учраас нэгтгэлд хамруулаагүй. Үүнд нийт **1,420,373,097 мянган төгрөгийг** тайлагнасан.

Олборлох үйлдвэрлэлийн компаниудын тайлагнасан эдгээр төлбөрийн задаргааг Тайлангийн 4.4 дээр харуулсан.

14. Бидний зүгээс мөн Монгол улсад хэрэгжиж буй ОУИТБС-ын үйл явц, ялангуяа энэхүү аудитын нэгтгэл, ОУИТБС-ын тайлан гаргахтай хамааралтайгаар тодорхой зөвлөмжүүдийг гаргасан. Эдгээр зөвлөмжүүдийг энэхүү тайлангийн Бүлэг 8 дээр тусган харуулсан.



Тим Вуудвард
Партнер
Мур Степенс



Ц.Жигдэн
Партнер
Далайван аудит ХХК

2013 оны 12 дугаар сарын 19 ний өдөр

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)

ОУИТБС-ын тухай анх 2002 онд Йоханесбург хотод болсон Тогтвортой хөгжлийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр анхлан зарлаж, 2003 онд Лондон хотноо үйл ажиллагааг нь албан ёсоор эхлүүлсэн юм. Тус санаачилгыг ашигт малтмал, газрын тос, байгалийн хий нь дэлхий нийтээр хүн ардын амьжиргаа, амьдралын чадавхыг дээшлүүлэхэд дэм болох бөгөөд энэхүү нөөцийг зохистойгоор удирдан чиглүүлээгүй тохиолдолд авлига болон мөргөлдөөнд хүргэж, олон хүний амьдралын чадавхыг муутгаж байдаг болохыг ухамсарласны үндсэн дээр хэрэгжүүлж эхэлсэн юм.

Тус санаачилга нь уул уурхайн салбарт ажиллаж буй компаниуд нь өөрийн төлсөн татварыг хэвлэн нийтэлж, нөгөө талаас төрийн байгууллагууд нь эдгээр компаниас хүлээн авсан төлбөрөө ил тод болгож байхад чиглэдэг. Тиймээс ОУИТБС нь ашигт малтмал, газрын тос, байгалийн хийгээр баян орнуудад сайн засаглалыг хөхүүлэн дэмжиж, тухайн улсын олборлох үйлдвэрлэлийн бий болгож буй хөрөнгийг буруугаар, өөр зорилгоор ашиглах эрсдлийг бууруулдаг. Тус санаачилга нь засгийн газар, хувийн компаниуд, иргэний нийгмийн бүлэг, хөрөнгө оруулагч нар болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаагаар дамжин хэрэгждэг.

ОУИТБС нь хэрэгжүүлж буй орон бүхэнд дэлхий нийтийн нэгдмэл стандартыг даган мөрдөхийг баталгаажуулдаг үр дүнтэй, уян хатан арга механизм юм. ОУИТБС-ын Удирдах зөвлөл, Олон улсын Ажлын алба нь энэхүү арга зүйг баталгаажуулж байдаг билээ. Үүнийг өөр өөрийн улс оронд хэрэгжүүлэх үүргийг тухайн улс орнууд хүлээдэг. ОУИТБС нь орон нутгийн түвшинд орлогын ил тод байдлыг ханган, дэлхий нийтийн стандарт бүхий санаачилга юм.

1.2 ОУИТБС Монгол улсад

2005 оны 10 дугаар сард УИХ-ын Төсөв болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар Монгол улсад ОУИТБС-ын зарчмуудыг даган мөрдөх тухай санал нэгдэн, улмаар энэхүү санаачилгад нэгдэн орохыг Засгийн газарт даалгажээ. Монгол улсын Засгийн Газар 2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаар ОУИТБС-ыг даган мөрдөх шийдвэр гарган, 1 тоот захирамжийг гаргасан байна.¹

2006 оноос хойш Монгол улс нь нийт 6 тайланг ОУИТБС-ын хүрээнд гаргаад байна (2006 - 2011). ОУИТБС-д хамрагдах төрийн байгууллагууд болон олборлох үйлдвэрлэлийн компанийн тоо жил тутам нэмэгдсээр байна. Доорх хүснэгт нь тайлан бүрийн хүрээнд гарсан ахиц дэвшлийг харуулсан:

Хамрах хугацаа	Хэвлэн нийтлүүлсэн огноо	Хамарсан салбар	ЗГ-ын орлого (сая ₮)	Компанийн төлбөр (сая ₮)	Тайлан гаргасан компанийн тоо
2006	2007 оны 12 сар	Уул уурхай	467,194	492,288	35
2007	2009 оны 11 сар (*)	Уул уурхай	748,783	745,004	38
2008	2010 оны 6 сар	Уул уурхай, газрын тос	684,953	686,054	46
2009	2011 оны 6 сар	Уул уурхай, газрын тос	737,525	737,583	76
2010	2012 оны 1 сар	Уул уурхай, газрын тос	1,275,062	1,275,063	150
2011	2012 оны 11 сар	Уул уурхай	2,150,734	2,150,809	200

(*) Зөвхөн анхлан тайлагнасан дүнг оруулсан.

¹ Эх сурвалж: Монголын ОУИТБС-ын вебсайт, <http://english.eitimongolia.mn>.

Хамаарах талуудын гарын үсэг зурсан Харилцан ойлголцлын санамж бичиг нь Засгийн Газар, олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон иргэний нийгэм ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэлтэй болохыг баталгаажуулсан байна. 2007 оны 4 дүгээр сарын 80 дугаар тогтоолоор ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий бүтцийг бий болгосон байна. 2010 оны 7 дугаар сард гарсан 19 дүгээр тогтоолоор Засгийн Газар нь 2011 оны санхүүгийн жилээс эхлэн ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцыг Ерөнхий сайдын төсвийн багцаас гарган санхүүжүүлэхээр болж, нийслэл орон нутгийн төрийн байгууллагууд, удирдлагад хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн төлсөн бүх татвар төлбөрийг ОУИТБС-ын хүрээнд тайлагнан ил тод болгож байх үүргийг ноогдуулсан байна. Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй Ашигт малтмалын хуулиар (§48.10) тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүтээгдэхүүн борлуулалт, төв болон орон нутгийн төсөвт төлсөн татвар болон төлбөрийг олон нийтэд ил тод болгож байхаар заажээ. Одоогоор ОУИТБС-ын хуулийн төслийн боловсруулах үйл ажиллагаа явагдаж байна.

Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийг Үндэсний зөвлөл хянан, зохицуулж байдаг. Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд Н.Алтанхуяг даргалдаг бөгөөд тус зөвлөл нь нийт 18 гишүүнтэй. Олон талын оролцоот Ажлын хэсэг нь ОУИТБС-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг. Ажлын хэсэг нь 31 гишүүнтэй бөгөөд тус Ажлын хэсгийг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүх даргалдаг.

Монгол улс дахь ОУИТБС-ын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг бүхий Ажлын албыг Монгол улсын Ерөнхий сайдын 2007 оны 6 сарын 20-ны өдрийн 62 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд тус алба нь 2011 оны 12 дугаар сараас хойш нийт 3 байнгын ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2006 оноос хойш ОУИТБС-ын хэрэгжилтийг Монгол улсад бэхжүүлэхийн тулд Монголын ОУИТБС нь 2010-2014 онуудад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг боловсруулан гаргаж, 2010 оны 6 сарын 27-д Үндэсний зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлж буй бөгөөд үүний зорилго нь ОУИТБС-ын эрх зүйн орчныг бий болгох, тайлан гаргах цар хүрээг өргөжүүлэх, зөрүүг тодруулах, зөрүүг магадлан шалгах, аудиторын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, санхүүжилтийн найдвартай эх үүсвэрийг бий болгох, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзлийг дэмжих иргэний нийгмийг оролцуулах, ОУИТБС-ыг орлогын хуваарилалт, тусгай зөвшөөрөл, нөхөн сэргээлтийн зардал, гэрээний ил тод байдлыг өргөжүүлэх, Монголын ОУИТБС-ын чадавхыг бэхжүүлэх зэрэг зорилгод чиглэж байна. Энэхүү баримт бичгийн үндсэн дээр жил бүрийн ажлын болон бизнесийн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.

Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтэд 2010 оны 2 дугаар сард баталгаажилт хийгдсэн. Баталгаажилтын тайланг судлан үзсэний дараа ОУИТБС-ын Удирдах зөвлөл Монгол улсыг 2010 оны 4 сарын 15-нд “нэр дэвшигч” орон хэмээн зарлаж, даган мөрдөгч орон хэмээн статусыг авахад ойртсон хэмээн үзсэн байна. Улмаар Монгол улсад 6 сарын хугацааг гарган өгч хэрэгжүүлэгч хэмээх статус авахын тулд хийж гүйцэтгэх ажлыг дуусгах үүргийг өгсөн байна. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Олон улсын Ажлын албанаас шалган үзэж, үүний тайланг Баталгаажуулалтын тайланд хавсарган хүргүүлсэн ба Удирдах зөвлөл нь 2010 оны 10 дугаар сарын 19-ны өдөр Монгол улсыг хэрэгжүүлэгч улс хэмээн зарласан юм.

1.3 Монгол улс дахь олборлох салбарын нөхцөл байдал

1.3.1 Газрын тос, байгалийн хийн салбар¹

а. Монгол улсын газрын тос, байгалийн хийн салбарын тухайн мэдээлэл

1940-өөд оны үед Монгол орны зүүн хэсэгт хуучин ЗХУ-ын геологчид Зүүнбаянгийн нефтийн ордыг илрүүлжээ. Тус ордын нөөцийг 6.2 сая тонн хэмээн тогтоож, Монгол улс дахь анхны газрын тос боловсруулах үйлдвэрийг 400,000 тонныг боловсруулах хүчин чадалтайгаар байгуулсан байна. Тус ордоос нийт 4 сая тонн түүхий тос олборлож, Оросоос оруулж ирсэн тостой хольж шатахуун гарган авснаар тухайн үеийн улсын нийт шатах, тослох материалын

¹ Эх сурвалж: <http://mongolianeconomy.mn>; Petroleum-Economist; ГТГ, Петровис; Дэлхийн Банк; Ройтерс; www.legalinfo.mn.

хэрэгцээний 20%-ийг хангаж байжээ. 1969 онд тус үйлдвэр татан буугдсан бөгөөд гол шалтгаан нь олборлолтын цооногийн даралт буурсан, үйлдвэрт гал гарсан болон бусад эдийн засгийн шалтгаанаар татан буугдсан байна.

1993 онд анхны БХГ-г АНУ-ын Соко компанитай байгуулсан бөгөөд 3000 метр гүнтэй анхны хайгуулын өрөмдлөгийг хийсэн байна. 1997 онд 19 дүгээр талбайн 19-3 дугаар цооногоос газрын тос гарсан байна. Үүнээс хойш удалгүй Монголоос газрын тосыг автомашинаар тээвэрлэн Хятад улсад экспортлох болжээ.

1993- 2011 онуудад нийт 28,300 кв.км газарт 2D чичирхийллийн судалгаа, 5,920 кв.км нутагт 3D чичирхийллийн судалгаа, 249,570 гравитацийн судалгаа, 154,521 соронзон судалгаа хийж 844 гүний цооног өрөмдөж, 239 цооногийг үйл ажиллагаанд оруулсан байна. Нийт 1.5 тэрбум ам долларын хөрөнгө оруулалтыг газрын тосны хайгуулын чиглэлээр Монгол улсад хийсэн байна.

Газрын тосны үйлдвэрлэл 1998 онд эхэлснээс хойш 10.58 сая баррел газрын тос үйлдвэрлэн үүнээс 9.89 сая баррелыг Хятадад гаргасан бөгөөд Монгол улсад боловсруулах үйлдвэргүйн улмаас түүхийгээр нь гаргажээ. 2010 онд Монгол улс нь газрын тос үйлдвэрлэгч орон хэмээн зарлагдсан бөгөөд 19 дүгээр талбай болон 97th PSC талбай нь баталгаат 272 сая тонн нөөцтэй хэмээн зарлагджээ.

Одоогийн байдлаар Монгол улсад нийт 531,000 кв.км талбайг хамарсан газрын тосны 30 талбай байгаа ба нийт дотоод, гадаадын 14 компанитай Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 18 талбайд ажиллаж байна. Нийт туслан гүйцэтгэгч, гэрээт компаниудын 33% нь дотоодын, 39% нь Хятадын, үлдэх 28% нь бусад орнуудын компаниуд байна. Олон улсын тендер шалгаруулалтаар нийт 5 талбайд санал авсан бөгөөд эцсийн дүн хараахан гараагүй байна.

b. Үйлдвэрлэл

Одоогоор Монгол улсад үйлдвэрлэл явуулж буй хоёр сав газар буй бөгөөд нэг нь зүүн өмнөд Говь нутагт орших Зүүнбаян бөгөөд энэ бүсэд 1953 оноос хойш 1969 он хүртэл олборлолт явуулж, улмаар 2007 оноос дахин эхлүүлэн 2012 оны 2 сарын 29-ний байдлаар 2.66 сая тонныг олборлоод байна. Тамсагийн сав газарт 1998 оноос үйлдвэрлэл эхлүүлсэн бөгөөд одоогоор олборлолт хамгийн идэвхтэй явагдаж байна. Тамсагт хийсэн үнэлгээгээр тус газрын нөөцийг 2011 оны байдлаар 2.07 сая тонн хэмээн тооцсон байна. 2012 онд Монгол улсын түүхий тосны үйлдвэрлэл 3.6 сая тонн гарч, жил тутамд 10%-иар өсөж байна.

	Нэгж	2009	2010	2011	2012
Газрын тос	1000 баррель	1,870	2,181	2,549	3,636

c. Эрх зүйн орчин

Газрын тосны газар нь 1990 онд анх үүсгэн байгуулагдсан төрийн байгууллага юм. Монгол улсын Газрын тосны тухай хуулийг 1991 оны 1 сарын 18-ны өдөр батлан гаргажээ. Энэхүү хууль нь Монгол улсад газрын тос хайх, хамгаалах, боловсруулах, хадгалах болон тээвэрлэхтэй холбоотой Монголын болон гадаадын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулдаг.

d. Тусгай зөвшөөрөл

Газрын тосны холбогдолтой үйл ажиллагаа явуулах боломжийг хангахын тулд орон нутгийн захиргаа нь газрын эрхийг олгодог бол Засгийн газраас тусгай зөвшөөрөл олгодог. Хайгуулын хугацаа нь 5 хүртэлх жил байдаг. ГТГ нь хамаарах нөхцлийг тохиролцож гэрээ хийх ба тусгай зөвшөөрлийн хугацааг хоёр удаа сунгаж болно.

Газрын тосны талбай дээрх үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс эхлэн 20 хүртэлх жил үргэлжилж болно. Хэрэв гэрээт олборлогч нь боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой зэргийг нэмж барьсан бол 5-аас илүүгүй жилийн хугацаагаар хоёр удаа сунгаж болно.

Газрын тосны гэрээний гол хэлбэр нь БХГ юм. Гэрээ байгуулахыг хүссэн этгээд нь ГТГ-д өөрийн өргөдлөө гарган БХГ хийх ба ингэхдээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн Газраас зөвшөөрөл авдаг.


1.3.2 Уул уурхайн салбар

а. Монгол улсын уул уурхайн салбарын тухай мэдээлэл

Монгол улс нь ашигт малтмалын ихээхэн нөөцтэй бөгөөд нийт 6000 гаруй орд газар болон 80 төрлийн эрдсийн илэрц нээгдээд байна. Хайгуулын үйл ажиллагаа жил тутам нэмэгдэж, олон тооны зэс, алт, уран болон бусад ашигт малтмалын орд нээгдэж байна.

Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засагт ихээхэн чухал үүргийг гүйцэтгэж байна. Нийт газар нутгийн ихээхэн хэсэг дээр геологи хайгуулын ажил хийгдэн, олон тооны нөөцийг нээн илрүүлж байна. 2012 онд уул уурхайн салбар нь Дотоодын нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 67%, ДНБ-ий 18%-ийг эзэлж байна.

Уул уурхайн салбарын хувь нэмэр



б. Үйлдвэрлэл

Монгол улсын өмнөд хэсэгт орших Говийн бүсэд буй Оюу Толгойн орд нь дэлхий дээрх хамгийн том алт-зэсийн орд бөгөөд тус орд нь жилд 500,000 тонн зэс, 330,000 унц (10 тонн) алтыг хамгийн багадаа 35 жилийн туршид үйлдвэрлэх боломжтой юм. Монгол улс нь одоо алт, зэс, молибден, уран зэрэг ашигт малтмал олборлогч чухал орон болоод байна.

2010-2012 оны голлох ашигт малтмалын үйлдвэрлэлийг доор харууллаа¹:

Бүтээгдэхүүн	Нэгж	2010	2011	2012
Нүүрс	Мянган тонн	25,162	32,030	31,139
Зэсийн баяжмал (35%)	Мянган тонн	357	347	348
Молибдений баяжмал (47%)	Тонноо	4,677	4,163	4,050
Алт	Кг	6,037	5,703	5,995
Жонш	Мянган тонн	727	659	484
Жоншы баяжмал	Мянган тонн	141	116	157
Төмрийн хүдэр	Мянган тонн	3,203	5,678	7,561
Цайрын хүдэр	Мянган тонн	113	105	119
Вольфрамын баяжмал	тонн	20	13	66
Давс	ton	-	-	569


¹ Эх сурвалж: УСГ.

2009-2012 оны экспортын нийт хэмжээ болон үнийн дүнг доор харууллаа²:

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2010		2011		2012	
		Тоо хэмжээ	Хэмжээ (Кг Долл)	Тоо хэмжээ	Хэмжээ (Кг Долл)	Тоо хэмжээ	Хэмжээ (Кг Долл)
Алт	Тонн	5	178,339	3	113,047	2.8	122,294
Зэсийн баяжмал	Мянган тонн	569	770,594	573	963,596	574	838,579
Молибденийн хүдэр болон баяжмал	Мянган тонн	5	51,989	4	46,394	4	38,174
Жоншны хүдэр болон баяжмал	Мянган тонн	406	68,825	407	94,877	429	102,507
Хайлуулсан зэс болон хайлуур жонш	Тонн	2,800	20,357	2,361	21,028	2,120	16 647
Төмрийн хүдэр	Мянган тонн	3,564	253,825	5,753	437,328	6,416	532,509
Нүүрс	Мянган тонн	16,726	881,998	21,106	2,250,046	20,916	1,901,773
Түүхий газрын тос	Мянган тонн	2,071	154,386	2,541	252,192	3,568	336,053
Цайрын хүдэр болон баяжмал	Мянган тонн	120	134,135	121	142,678	140.9	130,830
Нийт			2,514,449		4,321,186		4,019,366

Нүүрс

Монгол улс нь нүүрсний нөөцөөрөө дэлхийд эхний 10-т багтдаг орны нэг юм. Геологийн боломжит нүүрсний нийт хэмжээ нь 173.3 тэрбум тонн бөгөөд дэлхий дээрх нээгдсэн бүхийл ордын нөөцийн 10%-тай тэнцүү, 21.5 тэрбум тонны баталгаат нөөцтэй юм. Монгол улс нь 2012 онд 31 сая тонн нүүрс олборлож үүнээс 20.9 сая тонныг нь экспортлосон бөгөөд нүүрсний экспорт нь нийт экспортын 47%-ийг эзэлж, нийт 1.9 тэрбум төгрөгийн нүүрс гадагш борлуулсан байна.



Эх сурвалж: Ашигт малтмалын газар. 2013 оны 10 дугаарын сарын 1

Зэс

Монгол улсын тогтоогдсон зэсийн нийт нөөц нь 84.1 сая тонн бөгөөд Монгол улс нь зэсийн нөөцөөрөө дэлхийд дээгүүрт ордог. 2012 онд Монгол улсын зэсийн баяжмалын экспортын хэмжээ 574 мянган тоннд хүрсэн байна. Монгол улсад Оюу Толгой, Эрдэнэт гэсэн хоёр том уурхай үйл ажиллагаа явуулж байна¹.

Оюу Толгойн уурхай нь Монгол улсын өмнөд хэсэг Говийн бүсэд орших ба нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 км зайд оршино. Тус уурхайг Монгол улсын Засгийн Газар (34%) болон Туркойс Хилл Ресурсис (66%, компанийн 51%-ийг Рио Тинто эзэмшдэг) хамтран эзэмшиж байна. Оюу Толгойг анх 2001 онд нээн илрүүлсэн байна.

Оюу Толгой нь 45 сая тонн зэс агуулж байна. Оюу Толгой төслийн цар хүрэнээс үзвэл тухайн төслийг хэрэгжүүлэх хугацаа нь 50 гаруй жил байж болох юм.

Оюу Толгой нь ойролцоогоор 430,000 тонн зэс, 425,000 унц алтыг жил тутам олборлох боломжтой бөгөөд үүний зэрэгцээ мөнгө, молибдени зэрэг дайвар бүтээгдэхүүнийг мөн үйлдвэрлэх боломжтой юм. Оюу Толгойгоос олборлох хүдрийг уурхай дээрх баяжуулах үйлдвэрт боловсруулан эхний жилүүдэд олон улсын зах зээлд авто замаар тээвэрлэн хүргэнэ.

Эрдэнэтийн уурхай нь Улаанбаатар хотоос баруун хойд зүгт орших бөгөөд 7,5 сая тонн зэсийн нөөцтэй².

Алт

Монгол улс нь 2012 онд 6 тонн орчим алт олборлосон бөгөөд үүнээс 2.8 тонныг экспортод гарган 122 сая ам долларын орлого олсон байна. Бороогийн уурхай нь Улаанбаатар хотоос 100 орчим км зайтай орших бөгөөд тус орд дээр 2003 оноос хойш олборлолт явуулан нөөц нь дуусах дөхөөд байна. Тус уурхай нь Монголд үйл ажиллагаа явуулж буй үндсэн ордын нэг юм. Үүний зэрэгцээ Оюу Толгой нь 1800 тонн алтны нөөцтэй. Харин шороон орд дээр ажилладаг жижиг олборлогчид Монгол улсын алтны үйлдвэрлэлийн дийлэнх хувийг эзэлж байжээ. Байгаль орчны асуудлуудаас үүдэн 2009 онд усны эх, сав газар болон ойн нөөц бүхий газарт алт олборлохыг хориглосон хуулийг батлан гаргасан байна³.

Уран

Монгол улсад ураны хэд хэдэн томоохон орд газрууд буй бөгөөд эдгээрийн таамаг нөөц нь 30- 62 мянган тонноор хэмжигдэж буй юм.

Одоогоор стратегийн ач холбогдол бүхий 15 орд газар байгаагийн тоонд Мардайн орд, Дорнод аймгийн Дашбалбар суман дахь Дорнодын орд зэрэг ураны 2 орд байна. Одоогоор Монгол улс нь уран экспортлохгүй байна. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цөмийн энергийн газрын мэдээгээр 15 компани тусгай зөвшөөрлийн төлбөрт 2.9 тэрбум төгрөгийг төлжээ⁴.

с. Тусгай зөвшөөрөл

2012 оны 12 сарын эцсийн байдлаар нийт 3,540 тусгай зөвшөөрлийг нийт 20.2 сая га газрыг хамруулан олгоод байна. Эдгээр тусгай зөвшөөрлөөс 1,237 ашиглалтын зөвшөөрлийг 0.9 сая га газарт харин 2,303 хайгуулын тусгай зөвшөөрлийг 19.3 сая га газрыг хамааруулан олгожээ. Ойролцоогоор Монгол улсын нутаг дэвсгэрийн 12.9% нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зорилгод ашиглагдаж 0.6% нь олборлолтод, 12.3% нь хайгуулд хамаарч байна.


¹ Эх сурвалж:ҮСГ.

² Эх сурвалж: economy.news.mn.

³ Эх сурвалж: АМГ.


⁴ Эх сурвалж:Цөмийн энергийн газар 2013.10.28.

Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо



Эх сурвалж: Ашигт малтмалын газар. 2013 оны 10 дугаар сарын 1

Тусгай зөвшөөрлийн бүтэц, эрдсээр



Эх сурвалж: Ашигт малтмалын газар. 2013 оны 10 дугаар сарын 1

Хөрөнгө оруулалтын гэрээ

Хэрэв ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эхний 5 жилийн хугацаанд 50 сая ам доллараас багагүй хэмжээний хөрөнгө оруулалтыг хийх бол тухайн хөрөнгө оруулагчид тогтвортой орчныг ханган өгөх зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ хийж болно. Харин оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь 50 сая ам доллараас бага бол гэрээний хугацаа 10 жил, 100 саяаас дээш хэмжээний хөрөнгө оруулалтад 15 жил, харин 300 саяас дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийвэл гэрээний хугацаа 30 жил гэж¹ заасан байсан.

¹ Энэхүү хөрөнгө оруулалтын гэрээний хэсэг 2013 оны 10 сарын 3 ний өдөр хүртэл буюу 2013 онд шинээр Хөрөнгө Оруулалтын тухай хууль гарсантай холбоотойгоор өөрчлөгдсөн байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээ	Гэрээний хугацаа
50 сая ам доллар	10 жил
100 сая ам доллар	15 жил
300 сая ам доллар	30 жил

Хайгуулын тусгай зөвшөөрөл

Хайгуулын тусгай зөвшөөрлийг Монгол улсад татвар төлөгч, Монгол улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд олгоно. Хайгуулын талбайн хэмжээ нь 25 га-гаас багагүй харин 400,000 га-гаас хэтэрч болохгүй. Хуулийн этгээдийн эзэмшиж болох лицензийн тоог хязгаарлаагүй.

Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэхгүй байхаас сэргийлэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн байгаль хамгаалах зардлын 50%-тай тэнцэх мөнгөн дүнг хамаарах сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын нээсэн банкны тусгай дансанд байршуулах ёстой.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл:

Зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хайгуул хийсэн талбай дээр ашиглалт явуулах тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргаж болно. Тухайн ашиглалт явуулах газар нь хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дотор байна.

2. ЗОРИЛТУУД, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАНДЛАГА БОЛОН АРГА ЗҮЙ

Бид аудитын нэгтгэлийн үйл ажиллагааг Хамаарах үйлчилгээний олон улсын стандартын дагуу, ялангуяа 4400 дүгээр стандарт болох, 'Санхүүгийн мэдээлэлд хамаарах зөвшилцсөн горим болон Олон улсын аудитын холбооны Ёс зүйн дүрмийн дагуу явуулсан.

Энэхү аудитын нэгтгэл нь доорх зорилгыг агуулаагүй болно:

- Газрын тос болон ашигт малтмалын салбарт аудит болон хязгаарлагдмал байдлаар орлогын шалгалт хийгээгүй. Үүнээс үүдэн бидэнд гарган өгсөн мэдээллийн үнэн зөв байдалтай холбоотойгоор ямар нэгэн баталгаа өгөх боломжгүй; мөн
- Үйл ажиллагааг эрхлэн явуулж байх үеэр тулгарснаас бусад тохиолдолд алдаа, хууль бус үйлдэл болон бусад сөрөг байдлыг илрүүлэх зорилго агуулаагүй болно.

2.1 Зорилтууд

Энэхүү үйл ажиллагааны зорилт нь олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс төлсөн төлбөрийг Монгол улсын Засгийн Газрын харьяа байгууллагуудын зүгээс хүлээн авсан талаарх мэдээлэлтэй тулган нэгтгэх явдал байлаа. Ялангуяа бидний гэрээний Гүйцэтгэх ажлын тодорхойлолттой холбоотойгоор, бидний явуулсан гол үйл ажиллагаа нь доорх зорилтод чиглэсэн болно:

- Сонгон авсан олборлох үйлдвэрлэлийн компаниудын бүх материаллаг төлбөр, хайгуулын тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл бүтээгдэхүүн хуваах гэрээ зэрэгтэй холбоотой 2012 оны санхүүгийн жилийн төлбөр, орлогод дүн шинжилгээ хийн, нэгтгэх; болон
- Компанийн төлбөр болон Засгийн Газрын орлогыг задаргаатайгаар харуулсан, үүнд компани, төрийн байгууллага болон татвар, төлбөрийн төрөл бүр дээр задаргаатай харуулсан тайланг бэлтгэн гаргах.

2.2 Хандлага болон арга зүй

2.2.1 Мэдээлэл цуглуулах болон дүн шинжилгээ хийх

Үйл ажиллагааны эхний үе шат нь олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагуудын гарган өгсөн тайлангуудад дүн шинжилгээ хийж, ямар нэгэн боломжит алдаа буй эсэхийг илрүүлэх явдал байлаа. Харамсалтай нь олборлох үйлдвэрлэлийн компаниудын гаргасан тайлангууд нь зөвхөн тайлангийн маягтуудыг бөглөхөөр хязгаарлагдсан байсан бөгөөд татварт төлсөн нийт мөнгөн дүнг тайлагнан, харин үүнд хамаарах дэлгэрэнгүй мэдээллийг гарган өгөөгүй байв (Бүлэг 8. Үр дүн -8.1 ийг үзнэ үү).

Олборлох үйлдвэрлэлийн компаниуд

Компаниудын гаргасан тайлангийн маягтуудын хуулбарыг ОУИТБС-ын Ажлын албанаас аудитын нэгтгэл гүйцэтгэгчид гарган өгсөн. Эдгээр тайлангууд нь 2012 онд хийсэн төлбөрийг татвар, төлбөр, хандив зэргээр ангилан харуулсан байлаа. Гэхдээ тухайн төрлийн төлбөр нэг бүрт хамаарах төлбөр хийсэн дэлгэрэнгүй хуваарь болон бусад мэдээлэл байхгүй байлаа. Тайлангийн маягтууд нь мөн компаниуд өөрийн мэдээллээ оруулах, холбоо барих хаяг зэрэг мэдээлэл оруулах, тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэл болон борлуулалтын тухай мэдээлэл оруулах шаардлагатай хэсгүүдтэй байна. Гэсэн ч бүх компани шаардлагатай гэсэн бүх мэдээллийг бүрэн бөглөн ирүүлээгүй байлаа.

Бид 200 компанитай холбогдож, тэдний тухай дэлгэрэнгүй мэдээлэл, холбоо барих хаяг, утасны дугаар болон цахим шуудангийн хаяг зэрэг мэдээлэл авсан. Мөн албан бичгийг биечлэн болон цахим шуудангаар илгээн тэдний тайлагнасан мөнгөн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл авах оролдлогыг хийсэн.

Төрийн байгууллагууд

Төрийн байгууллагуудын хувьд ямар нэгэн төлбөр хүлээн авдаг байгууллагын тоо маш олон байсан тул бөглөсөн тайлангийн маягтуудыг Татварын ерөнхий газар цуглуулан авч, нэгтгэсэн. Нэгтгэл гаргагчид компаниудаас хүлээн авсан бүтэн жилийн нийт татварыг жагсаасан Эксел програмын хуудсыг гарган өгсөн. Энэхүү нэгтгэсэн хуудас нь тусгай зөвшөөрөл эзэмшигч 1,829 компаниас хүлээн авсан татварыг тусгасан байв. Харин компанитай хамаарах төлбөрийн тайлагналын хувьд төрийн байгууллагад төлсөн төлбөр нэг бүрийг нарийвчлан харуулах дэлгэрэнгүй мэдээлэл байсангүй. Нэгтгэл гаргагч нь хамаарах төрийн байгууллагуудтай холбоо барих тухайн тайлагнасан мөнгөн дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч ажилласан.

Бид үүний хүрээнд хамаарах төрийн байгууллагууд жишээ нь ТЕГ, ГЕГ, БОНХЯ, Хөдөлмөрийн яам, АМГ, МХЕГ, НДЕГ, ГТГ, ЦЭГ зэрэг байгууллагуудад хандан тайлагнсан мөнгөн дүнгийнх нь талаар тодруулга авсан.

2.2.2 Материаллаг байдлын босго

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл нь 2010 оны 6 дугаар сарын 24-ний хуралдаанаараа олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс төрийн байгууллагуудад нийт **10.000,0** мянган төгрөгөөс дээш хэмжээний мөнгийг төлсөн л бол тайлагнаж байх ёстой хэмээн тогтоожээ. 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар гишүүд 2012 оны нэгтгэлд хамрагдах компанийг нийт **40.000,0 мянган төгрөгөөс** дээш хэмжээний төлбөр төлсөн бол хамруулахаар тогтсон байна. Ингэснээр 2012 оны нэгтгэлд нийт **200** компанийг хамруулахаар болсон байна.

Харамсалтай нь олборлох үйлдвэрлэлийн нийт салбарын орлогын талаар мэдээ баримт байхгүй тул ОУИТБС-д хамрагдаж буй төлбөрийн төрөл, урсгал нь тухайн салбараас авч буй нийт татварт хэр хувь хэмжээг эзлэх болохыг үнэлэн гаргах боломжгүй байсан билээ (Бүлэг 8. Үр дүн -8.1 ийг үзнэ үү).

2.2.3 Материаллаг байдлын зөрүү

Компаниудын хийсэн төлбөр болон төрийн байгууллагуудын хүлээн авсан орлогын хоорондын зөрүүн дээр тохируулга хийгдсэний дараагаар алдааны материаллаг нь **100,0** мянган төгрөг байхаар аудиторуд тогтоосон. Энэхүү алдааны материаллагыг татвар нэг бүрээр нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдах хамгийн бага босго бөгөөд үүнийг нэгтгэлийн үйл ажиллагааны хүрээнд тохируулга хийхэд ашигласан. Өөрөөр хэлбэл зөвхөн 100,0 мянган төгрөгөөс дээш хэмжээний зөрүү гарах тохиолдолд шалган тохируулга хийсэн.

2.2.4 Хандив тусламжийн асуудал

Тайлангийн маягт нь хандив тусламжийг 2 бүлэглэн оруулсан байна. Нэг бүлэг буюу ангилал нь “Үндсэн төлбөр” хэмээх ангилалд багтах бөгөөд төрийн байгууллагуудад өгсөн хандив, тусламжийг хамаарна. Нөгөө бүлэг буюу ангилал нь “Сайн дурын” хэмээх ангилал бөгөөд энэ нь ТББ-уудад өгсөн хандив, тусламжийг хамарна.

Аудитын нэгтгэлийн үйл ажиллагааг зөвхөн “Үндсэн төлбөр” хэмээх ангилал дээр гүйцэтгэсэн бөгөөд энэ нь тайлангийн маягтын Б хэсэг дээр багтах юм (Үндсэн мэдээлэл). Сайн дурын төлбөр, хандивын хувьд энэ нь маягтын В хэсэг “Сайн дурын” гэсэн хэсэгт орох бөгөөд энэ тохиолдолд зөвхөн компанийн зүгээс гаргасан нэг талын мэдээллийг ашигласан.

Бүлэг Б дээр мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр олгосон хандив тусламжийг нэгтгэлд хамруулсан. Эдгээр баримт бичгүүдийг нэгтгэлд хамруулахад ихээхэн хүндрэлтэй байсан бөгөөд учир нь гаргасан тайлан хангалтгүй, ялангуяа Засгийн Газрын зүгээс хүндрэлтэй байсан болохыг тэмдэглэж байна. Бидний үзэж буйгаар энэ хандив нь “Үндсэн төлбөр” хэсэгт багтсан тул хамруулж буй юм. Түүнчлэн хандив нь мөнгө болон мөнгөн бусаар олгосон хандивыг хамруулж буй бөгөөд мөнгөн бус хэлбэрээр өгсөн хандивын үнэлгээг хүлээн авагч тал үнэлэх нь ихээхэн хүндрэлтэй нь ойлгомжтой.

2.2.5 Олборлох үйлдвэрлэл эрхлээгүй компаниудын тайлан

Хайгуулын эсвэл ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй гэхдээ ямар нэгэн олборлох үйл ажиллагааг явуулаагүй компаниудын хувьд бид тэдний гаргасан тайланг зөвхөн олборлох салбарт хамаарах татвар, төлбөр, хураамжаар нь ялангуяа тусгай зөвшөөрлийн төлбөрөөр нь хязгаарлан нэгтгэлд хамруулсан. Бусад бүх төлбөрийг “Тэг” хэмээн үзэж тохиргоо хийсэн. Энэхүү ангилалд хамаарах компаниудын нэрийг доор харууллаа:

№	Компани
26	Билгүүнтрейд ХХК
30	Бридж Констракшн ХХК
81	Макс Импекс ХХК
107	Орчлон Констракшн ХХК
130	Таван толгой транс ХХК
150	Хера Инвестмент ХХК
199	ЭСТО ХХК

2.2.6 Хийж гүйцэтгэсэн нэгтгэлийн үйл ажиллагаа

Бид нэгтгэлийн ажлыг компани нэг бүрээр, төлбөрийн төрөл урсгал нэг бүрээр хийсэн бөгөөд ингэхдээ зөвхөн талуудын нэмэлтээр гарган өгсөн дэлгэрэнгүй мэдээлэл дээр үндэслэн нэгтгэлийг хийж гүйцэтгэсэн.

Нэгтгэлд баримталсан 100,0 мянган төгрөгөөс дээш гарсан бүх зөрүүг хамаарах компани болон төрийн байгууллагад мэдэгдэж, дэмжих баримтуудыг гаргуулан авч, тайлбар авч шаардлагатай тохирлуулгыг хийж гүйцэтгэсэн. Харин дэмжих баримтууд эсвэл бусад тайлбарыг нөгөө талаас гарган өгөөгүй зөрүүний хувьд энэхүү тайлан дээр шийдэгдээгүй буюу тохируулга хийгдээгүй хэмээн оруулсан болно.

Гарсан зөрүүнүүдийг доорх байдлаар ангилан оруулсан:

- Эерэг зөрүү: олборлох үйлдвэрлэлийн компанийн зүгээс төлсөн хэмээн тайлагнасан нийт дүн нь төрийн байгууллагын зүгээс авсан хэмээн тайлагнасан төлбөрөөс илүү гарсан;
- Сөрөг зөрүү: олборлох үйлдвэрлэлийн компанийн зүгээс төлсөн хэмээн тайлагнасан нийт дүн нь төрийн багууллагын зүгээс авсан хэмээн тайлагнасан төлбөрөөс дутсан; болон
- Цэвэр зөрүү: эерэг болон сөрөг зөрүүний нийлбэр.

Мэдээлэл цуглуулан нэгтгэх болон тогтоосон зөрүүний талаар тайлагнах боломжийг хангахын тулд бид Майкрософт Эксел програм дээр мэдээллийн санг олборлох компани нэг бүрээр үүсгэж тэдний тайлагнсан бүх төрлийн төлбөрийг оруулан, хамаарах төрийн байгууллагын хүлээн авсан орлогын дүнтэйгээр хамт оруулан үйл ажиллагаандаа ашигласан.

Дээр дурдсан нэгтгэлийн мэдээллийн санг ашиглан бид нэгтгэл хийхэд шаардлагатай, ямар нэгэн зөрүүг тодруулахад хэрэгцээтэй мэдээллийг тогтоон гарсан бөгөөд үүнийг компани нэг бүрээр, төлбөр нэг бүрээр гаргасан.

Харин төрийн байгууллагуудын зүгээс тайлагнасан дүн нь компаниудын тайлагнасан дүнтэй таарсан тохиолдолд төрийн байгууллагын тайлагнасан дүн нь компанийн тайлангаар батлагдсан хэмээн үзэж байв. Хэрэв батлагдахгүй бол үүнийг зөрүүний гарал үүслээр нь ялган ангилж, тэдгээрийг тодруулах чиглэлээр хийх арга хэмжээг тодорхойлон үнэлгээ хийж гүйцэтгэсэн (тодруулга гарган өгөхийг хүсэх, нэмэлт мэдээлэл, дэмжих баримт бичиг хүсэмжлэх, очиж ажиллах гэх мэт).

Энэхүү гарсан зөрүүг тогтоон шалгасны дараа бид тухайн тайланг гаргасан, гэвч тайлан нь буруу эсвэл бүрэн бус байсан байгууллагуудтай эргэн холбоо барьж байсан. Буруу буюу алдаатай тайлагнал нь нэг байгууллагын тайлан дээр эсвэл хоёр талын аль алиных нь тайлан дээр үүсэн гарч байсан. Эхний тохиолдолд тухайн байгууллагатай утсаар болон цахим шуудангаар харилцан энэ талаар тайлбар өгөхийг эсвэл дэмжих баримт материалуудыг (нарийвчилсан төлбөрийн мэдээлэл, нотолгоо, төлбөр төлсөн байгууллагын тухай мэдээ гэх мэт) гарган өгөх хүсэлт гаргаж байв. Бидэнд гарган өгсөн баримтуудыг судлан үзэж, тайланд дахин үнэлгээ хийн тухайн алдаа болон зөрүүг тайлбарлах, тохируулга хийх боломжтой эсэхийг судлан шалгах байдлаар үйл ажиллагаагаа үргэлжүүлэн гүйцэтгэсэн.

Бүх тохируулгыг олборлох үйлдвэрлэлийн компаниуд эсвэл төрийн байгууллагуудаас гарган ирүүлсэн баталгаа нотолгоо, дэмжих баримт бичгүүд дээр суурилан хийсэн.

Нэгтгэлийн үйл ажиллагааны үеэр бид томоохон хэмжээний бүх сул талуудыг илрүүлэн гаргаж, цаашид анхаарах асуудлуудыг тодруулахыг зорьсон. Эдгээрийг бүгдийг нь тайлангийн Бүлэг 8 дээр дэлгэрэнгүй харуулсан.

2.2.7 Төлбөрийн тайлагналт – мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал

ОУИТБС-ын Шаардлага 12 болон 13-ын дагуу компани болон Засгийн Газрын тайлан нь олон улсын стандартын дагуу хийгдсэн аудитын тайлан дээр суурилагдан гарч байх шаардлагатай.

Дотоодын хууль тогтоомжид ч мөн доорх байдлаар дурдсан байдаг:

- Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлд дараахь зарчмыг баримтална: аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх;¹ Санхүүгийн тайлан нь олон улсын санхүүгийн тайлангийн стандартад нийцсэн байх;²
- Төрийн байгууллагуудын санхүүгийн тайлан нь олон улсын стандартын дагуу байна (IPSAS)²;
- 50 сая төгрөг түүнээс дээш актив бүхий аж ахуйн нэгж байгууллагууд санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулсан байна. Аудитыг Олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ (ISA).³; мөн
- төрийн аудитын байгууллагаас улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахад дагаж мөрдөнө. Үүнийг олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ⁴.

Гэсэн ч ОУИТБС-ын хүрээнд тайлан гаргаж буй аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглах тайлангийн маягтай холбоотойгоор энэ талаар ямар нэгэн онцгойлсон зааварчилгаа өгөгдөөгүй байна. Зөвхөн нэг компанийн тайлан л хөндлөнгийн аудитаар баталгаажсан байсан болохыг тэмдэглэж байна (Бүлэг 8. Үр дүн -8.5 ийг үзнэ үү).

Гүйцэтгэх ажлын даалгаварт заасны дагуу бид олборлох үйлдвэрлэлийн бүх компаниас өөрийн ашигладаг нягтлан болх бүртгэл болон аудитын горимын тухай мэдээлэл гарган өгөх хүсэлтийг тавьсан бөгөөд энэхүү ажлын талаарх тойм мэдээллийг тайлангийн Хавсралт 5 дээр оруулж өгсөн.

¹ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 4 дүгээр зүйл, 2001 оны 12 сар.

² Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 10 дугаар зүйл, 2001 оны 12 сар.

³ Аудитын тухай хууль, 7-9 дүгээр зүйл, 1997 оны 5 сар.

⁴ Төрийн аудитын тухай хууль, 4 болон 7 дугаар зүйл, 2003 оны 1 сар.

2.2.8 Валютын төлбөрийн тайлан

Ам доллараар тайлагнасан төлбөрийн хувьд тухайн компани нэг бүрээр авч ашигласан ханшийг тогтоох боломжгүй байсан, үүнийг баталгаажуулах боломжгүй тул бид Монгол Банкны вебсайт дээр гардаг валютын ханшийн мэдээг ашигласан ([http: // www.mongolbank.mn/](http://www.mongolbank.mn/)).

3. АУДИТЫН НЭГТГЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

3.1 ОУИТБС-д хамрагдах олборлох үйлдвэрлэлийн компаниуд

2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хуралдаанаар гишүүд 2012 оны нэгтгэлд хамрагдах компанийг нийт **40 саяаас** дээш хэмжээний төлбөр төлсөн бол хамруулахаар тогтсон байна. Ингэснээр 2012 оны нэгтгэлд нийт **200** компанийг хамруулахаар болсон байна. Хамрагдсан компаниудын тухай мэдээлэл бүхий бүрэн жагсаалтыг тайлангийн Хавсралт 2 дээр оруулсан. Доорх хүснэгт дээр тухайн компаниудыг үйл ажиллагааны төрлөөр нь ангилан харууллаа:

6.1 2012 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайланд тусгагдсан уул уурхайн компаниудын төлбөр

Нэгтгэлд уул уурхайн компаниудын төлсөн төлбөрүүдийг доор хүснэгтэнд харуулав.


Компанийн нэр	ЗГ-ын хүлээн авсан дүн (мянган төгрөг)	Хувь
Эрдэнэт үйлдвэр ХХК	519,726,775	32.61%
Оюу толгой ХХК	201,918,246	12.67%
Энержиресурс ХХК	111,928,313	7.02%
Петрочайна дачин тамсаг ХХК	104,864,082	6.58%
Монголын Алт МАК ХХК	86,103,290	5.40%
Эрдэнэс МГЛ ХХК	80,142,183	5.03%
Тавантолгой ХК	58,485,547	3.67%
Эрдэнэс Таван толгой ХК	41,392,755	2.60%
Болдтөмөр Ерөө гол ХХК	37,908,463	2.38%
Саусгоби сэндс ХХК	37,715,532	2.37%
Бусад	313,568,489	19.67%
Нийт дүн	1,593,753,675	100%



6.2 2012 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайланд тусгагдсан татварын төрөл

Нэгтгэлд хамрагдсан төлбөрүүдийг татварын төрлөөр нь доорх хүснэгтэнд харуулав.


Үзүүлэлт	ЗГ-ын хүлээн авсан дүн (мянган төгрөг)	Хувь
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	510,410,648	32.03%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	219,179,003	13.75%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	192,321,230	12.07%
Төрийн өмчийн ногдол ашиг	114,621,665	7.19%
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	102,316,584	6.42%
БХГ-ний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	100,885,111	6.33%
Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаа төлбөрүүд	80,000,000	5.02%
Бусад	274,019,434	17.19%
Нийт дүн	1,593,753,675	100%



6.3 2012 оны Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын тайланд тусгагдсан уул уурхайн үйл ажиллагааны төрөл

Нэгтгэлд хамрагдсан төлбөрүүдийг хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны төрлөөр нь доорх хүснэгтэнд харуулав.


Үйл ажиллагааны чиглэл	ЗГ-ын хүлээн авсан дүн (мянган төгрөг)	Хувь
Ашигт малтмалын олборлолт	1,135,508,960	71%
Ашигт малтмалын хайгуул болон олборлолт	171,302,790	11%
Ашигт малтмалын хайгуул	146,987,123	9%
Газ, газрын тосны олборлолт	105,555,021	7%
Газ, газрын тосны хайгуул болон олборлолт	32,377,959	2%
Газ, газрын тосны хайгуул	2,012,432	0.13%
Бусад	9,391	0%
Нийт	1,593,753,675	100%



6.4 Орон нутгийн төсвийн төлбөрийн шинжилгээ

Уул уурхайн компаниудын орон нутгийн төсөвт төлсөн 92,841,103 мянган төгрөгийн татвар, төлбөр хураамжийг доорх хүснэгтэнд хүлээн авагч тус бүрээр үзүүлэв. Хүлээн авагч татварын төрөл тус бүрээр Хавсралт 6 дээр дэлгэрэнгүй үзүүлсэн болно.


Хүлээн авагч	Компанийн төлсөн дүн (мянган төгрөг)	Төлбөрийн эзлэх хувь
Өмнөговь аймаг	49,485,603	53%
ТЕГ	13,913,195	15%
Орхон аймаг	10,475,050	11%
Булган аймаг	6,873,300	7%
ХХҮХ	3,338,929	4%
БОНХЯ	1,731,933	2%
Бусад	7,023,093	8%
Нийт	92,841,103	100%



6.5 Орон нутагт өгсөн хандив, дэмжлэгийн шинжилгээ

Төрийн байгууллагуудад өгсөн 14,518,876 мянган төгрөгийн хандив тусламжийг доорх хүснэгтэнд хүлээн авагчаар нь үзүүлэв. Хандив дэмжлэгийн төрөл болон хүлээн авагч тус бүрийн дэлгэрэнгүйг Хавсралт 7 дээр дэлгэрэнгүй үзүүлсэн болно.

Хүлээн авагч	Компанийн төлсөн дүн (мянган төгрөг)	Төлбөрийн эзлэх хувь
Эрүүл мэндийн яам	5,696,028	39%
Өмнөговь аймаг	3,863,259	27%
Ховд аймаг	1,133,052	8%
Сэлэнгэ аймаг	1,125,784	8%
Бусад	2,700,753	18%
Нийт	14,518,876	100%



7. Бусад нэмэлт ажлууд

7.1 Уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа

Ажлын даалгаварт зааснаар бид нэгтгэл тайланд хамрагдсан нийт 200 компанийн судалгааг хийх ёстой байсан. Үүнээс АМГ-аас 84 компанийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийн мэдээллийг компаниудын олборлож буй бүтээгдэхүүн тус бүрээр гарган ирүүлсэн. Уг мэдээлэлд хамрагдаагүй компаниудыг авч үзвэл:

- Ашиглалтын лиценз эзэмшидэг 38 компани
- Ашиглалт болон хайгуулын лиценз эзэмшидэг 20 компани
- Хайгуулын лиценз эзэмшидэг 58 компани байна.

Эдгээр компаниудын уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 23 нэр төрлийн бүтээгдэхүүнээр гарган доорхи хүснэгтээс үзүүлэв. (Бүтээгдэхүүний хэмжээг тухайн бүтээгдэхүүний хэмжих нэгжээр илэрхийлэв) Дэлгэрэнгүйг Хавсаралт № 8 үзнэ үү.

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Компанийн тоо	Хөрс хуулалт, мян.м3			Хүдэр олборлолт, мян.м3			Хүдэр боловсруулалт, мян.м3			Бүтээгдэхүүн гаргалт, Аи, Аг-кг, Элс, хайрга-мян.м3, Си, Мо, Fe, Zn, W, Sn, Нүүрс, Жонш, Шохой, мян.тн, Тоого-сая.ш			Бүтээгдэхүүн борлуулалт Аи, Аг-кг, Элс, хайрга-мян.м3, Си, Мо, Fe, Zn, W, Sn, Нүүрс, Жонш, Шохой, мян.тн, Тоого-сая.ш (кг)		
			Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь
1	Алт	32	45,342.4	18,999.8	41.9	16,565.6	13,426.2	81.0	17,666.4	12,067.2	68.3	9,968.2	4,201.7	42.2	7,780.3	4,001.0	51.4
2	Битум	1	20.5	-	-	14.6	0.6	4.3	14.6	-	-	14.6	0.6	4.3	-	0.6	100.0
3	Бүхэллэг жонш 45%	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	1.1	100.0	-	1.1	100.0
4	Гөлтгөнө	1	31.8	25.9	81.4	12.1	10.4	86.6	12.0	-	-	-	10.4	100.0	-	3.3	100.0
5	Гянтболд	1	-	-	-	-	9,298.3	100.0	-	9,298.3	100.0	-	106.0	100.0	-	106.0	100.0
6	Дайрга	3	4.0	17.8	449.3	142.6	226.5	158.8	22.6	214.5	948.4	142.6	226.5	158.8	142.6	246.5	172.9
7	Жонш	1	120.0	-	-	440.0	-	-	531.7	-	-	120.0	-	-	120.0	-	-
8	Жоншны хүдэр	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	0.4	100.0	-	0.4	100.0
9	Зэс	1	32,671.7	6,313.7	19.3	31,995.8	28,066.0	87.7	25,650.0	26,030.0	101.5	500,770.8	517.8	0.1	498,660.0	517.8	0.1
10	Молибдени	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	3.9	100.0	-	4.0	100.0
11	Мөнгө	28	-	-	-	-	-	-	-	-	-	10,352.6	609.3	5.9	-	1,210.6	100.0
12	Нүүрс	24	199,781.0	143,685.3	71.9	40.0	-	-	-	-	-	49,204.0	29,411.2	59.8	46,370.2	26,281.4	56.7
13	тоосго	1	-	-	-	7.6	10.0	132.5	7.5	10.0	133.6	3.1	4.1	131.6	3.1	4.1	131.6
14	Төмөр, төмрийн баяжмал	17	31,606.9	17,190.6	54.4	20,911.8	11,294.3	54.0	19,849.6	9,589.9	48.3	10,816.7	6,081.0	56.2	10,879.7	5,811.0	53.4
15	Хар тугалга	2	-	-	-	660.0	-	-	660.0	-	-	11,614.3	-	-	10,328.0	-	-
16	Холимог металл	3	1,609.5	30,115.8	1,871.1	450.0	7,872.0	1,749.3	-	-	-	-	-	-	-	-	-
17	Хөнгөн дүүрэгч алевролит хөөлтийн коэффициент 1.59	1	0.6	0.6	100.0	30.0	1.1	3.7	30.0	0.5	1.6	8.8	0.5	5.5	-	0.5	100.0
18	Цагаан мөнгө	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	1,362.4	100.0	-	1,362.4	100.0
19	Цагаан туглага	1	39.0	388.0	994.9	27.2	20.0	73.5	127.2	20.0	15.7	32.9	0.1	0.3	32.9	0.1	0.3
20	Цайр	4	1,358.2	1,236.5	91.0	64,438.6	441.5	0.7	64,434.3	398.7	0.6	26,912.0	118.0	0.4	25,843.0	125.2	0.5
21	Шавар	1	15.0	14.0	93.3	30.0	28.0	93.3	-	-	-	30.0	28.0	93.3	-	28.0	100.0
22	Шохойн чулуу	2	1,270.1	370.0	29.1	676.0	561.4	83.0	216.2	555.2	256.8	216.2	561.4	259.7	216.2	505.9	234.0
23	Элс,хайрга	4	4,991.9	563.2	11.3	31,799.1	136.7	0.4	31,554.3	136.7	0.4	749.2	121.2	16.2	297.7	75.9	25.5
Нийт			318,862.6	218,921.3	68.7	168,240.9	71,393.1	42.4	160,776.3	58,321.0	36.3	620,956.0	43,365.5	7.0	600,673.6	40,285.7	6.7

Алт олборлодог 32 компианаас хөрс хуулалт, хүдэр олборлолт, боловсруулалт болон бүтээгдэхүүн гаргалт, борлуулалтаараа томоохон дүн бүхий 7 компанийг сонгож уулын ажлын төлөвлөгөө ба гүйцэтгэлийн судалгааг гаргав. Дэлгэрэнгүйг доорхи хүснэгтээс үзнэ үү.

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Хөрс хуулалт, мян.м3			Хүдэр олборлолт, мян.м3			Хүдэр боловсруулалт, мян.м3			Бүтээгдэхүүн гаргалт, кг			Бүтээгдэхүүн борлуулалт, кг		
		Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь
1	Алтандорнод Монгол ХХК	8,199.0	4,230.9	51.6	330.1	129.6	39.3	330.1	129.6	39.3	1,101.9	379.6	34.4	1,101.9	379.6	34.4
2	Бороогоулд ХХК	1,891.0	1,989.0	105.2	1,764.3	960.7	54.5	3,351.3	960.7	28.7	2,114.7	2,001.0	94.6	-	2,173.0	100.0
3	Булгангангат ХХК	1.1	1,400.0	132,827.3	60.9	57.4	94.2	60.9	57.4	94.2	131.0	65.2	49.8	131.0	65.2	49.8
4	Бумбат ХХК	2,218.2	2,991.0	134.8	199.0	232.2	116.7	199.0	232.2	116.7	389.3	477.8	122.7	389.3	477.8	122.7
5	Монголросцветмет ХХК	1,488.1	450.0	30.2	402.0	52.0	12.9	401.0	52.0	13.0	196.9	48.8	24.8	196.9	53.7	27.3
6	Мондолимет ХХК	1,195.4	1,395.2	116.7	2,127.2	1,877.0	88.2	2,127.2	1,877.0	88.2	521.5	390.1	74.8	521.5	20.9	4.0
7	Олон-Овоот гоулд ХХК	26,195.0	-	-	1,038.5	-	-	559.1	-	-	2,106.1	-	-	2,106.1	-	-
Нийт		41,187.7	12,456.1	30.2	5,922.0	3,308.9	55.9	7,028.5	3,308.9	47.1	6,561.3	3,362.5	51.2	4,446.6	3,170.2	71.3

Нүүрс олборлодог 24 компианаас хөрс хуулалт болон бүтээгдэхүүн гаргалт, борлуулалтаараа томоохон дүн бүхий 8 компанийг сонгож уулын ажлын төлөвлөгөө ба гүйцэтгэлийн судалгааг гаргав. Дэлгэрэнгүйг доорхи хүснэгтээс үзнэ үү.

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Хөрс хуулалт, мян.м3			Хүдэр олборлолт, мян.м3			Хүдэр боловсруулалт, мян.м3			Бүтээгдэхүүн гаргалт, тн			Бүтээгдэхүүн борлуулалт, тн		
		Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь	Төл	Гүй	Хувь
1	Энержиресурс	44,947.0	47,747.0	106.2	-	-	-	-	-	-	10,000.0	8,597.7	86.0	10,000.0	7,823.0	78.2
2	Монголын алт МАК	34,163.4	22,155.9	64.9	-	-	-	-	-	-	10,500.0	5,820.7	55.4	10,500.0	5,812.3	55.4
3	Саусгоби сэндс	26,038.0	3,362.5	12.9	-	-	-	-	-	-	5,607.0	1,344.4	24.0	5,000.0	1,344.4	26.9
4	Багануур	15,700.0	15,259.8	97.2	-	-	-	-	-	-	3,300.0	3,541.6	107.3	3,300.0	3,541.6	107.3
5	Эрдэнэс Таван толгой	11,881.0	8,532.2	71.8	-	-	-	-	-	-	3,780.0	2,504.1	66.2	3,000.0	2,386.0	79.5
6	Тавантолгой	9,780.1	-	-	-	-	-	-	-	-	2,000.0	-	-	2,000.0	-	-
7	Мөнхноён суварга	7,602.0	4,294.6	56.5	-	-	-	-	-	-	3,000.0	552.5	18.4	3,000.0	13.6	0.5
8	МОЭНКО	5,485.0	-	-	-	-	-	-	-	-	1,518.2	720.0	47.4	1,297.1	199.7	15.4
Нийт		155,596.5	101,352.0	65.1	-	-	-	-	-	-	39,705.2	23,080.9	58.1	38,097.1	21,120.7	55.4

Уулын ажлын төлөвлөгөө ба гүйцэтгэлийг АМГ-аас гаргаж ирүүлсэн мэдээлэлд үндэслэв.

7.2 Нөхөн сэргээлтийн судалгаа

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн мэдээг АМГ-аас ирүүлсэн 71 компаний нөхөн сэргээлтийн төлөвлөгөө гүйцэтгэлийг техникийн, шимт хөрсний, биологийн төрлүүд болон зарцуулсан хэмжээгээр нэгтгэн гаргаж доорхи хүснэгтэнд харуулав. Дэлгэрэнгүйг Хавсралт 9-ээс харна уу.

Үзүүлэлт		Дүн (мянган төгрөг)
Техникийн нөхөн сэргээлт, га	Төлөвлөгөө	355.9
	Гүйцэтгэл	504.2
	Хувь	142
Шимт хөрсний нөхөн сэргээлт, га	Төлөвлөгөө	270.3
	Гүйцэтгэл	334.1
	Хувь	124
Биологийн нөхөн сэргээлт, га	Төлөвлөгөө	237.1
	Гүйцэтгэл	263.3
	Хувь	111
Зарцуулах хөрөнгийн хэмжээ, сая.төг	Төлөвлөгөө	3,667.9
	Гүйцэтгэл	11,101.8
	Хувь	303

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн мэдээллээ ирүүлээгүй 129 компаний үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл:

- 46 компани хайгуулын,
- 8 компани газрын тосны,
- 4 компани ураны хайгуулын,
- 71 компани ашиглалтын лиценз эзэмшдэг бөгөөд нөхөн сэргээлтийн мэдээгээ АМГ-т ирүүлээгүй байна.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн тайлан ирүүлсэн болон ирүүлээгүй компаниудын жагсаалт

А. Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлсэн компаниуд			Б.Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлээгүй компаниуд			
№	компани	Ашигт малтмалын олборлолтын компани	Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлэх байсан боловч ирүүлээгүй компаниуд	Ашигт малтмалын хайгуулын компани	Газрын тосны компани	Ураны хайгуулын компани
1	Авдарбаян ХХК	✓				
2	АГМ майнинг ХХК		✓			
3	Адамас майнинг ХХК					✓
4	Адил оч ХХК		✓			
5	Адуунчулуун ХК	✓				
6	Азиагоулд Монголиа ХХК		✓			
7	Алтайн хүдэр ХХК		✓			
8	Алтан дорнод монгол ХХК	✓				
9	Алтанрио монголия ХХК			✓		
10	Анд Сөүрвэй ХХК	✓				
11	Андын-Илч ХХК	✓				
12	Аниан Ресорсиз ХХК		✓			
13	Анхай Интернэшнл ХХК		✓			
14	АУМ ХХК		✓			
15	Багануур ХК	✓				
16	Бадмаараг хаш ХХК	✓				
17	Батумайнинг Монгол ХХК			✓		
18	Баялаг-Орд ХХК	✓				
19	Баян эрч ХХК	✓				
20	Баян-Айраг Эксплорэйшн ХХК		✓			
21	Баянтэгш Импекс ХХК	✓				
22	Баянтээг ХК	✓				
23	Би Ди Би Эл ХХК			✓		
24	Би Си Эм Эм ХХК		✓			
25	Би Эйч Эм ХХК		✓			
26	Билгитнтрейд		✓			
27	Блейк маунт майнинг ХХК			✓		
28	Болдтөмөр Ерөө гол ХХК	✓				
29	Бороогоулд ХХК		✓			
30	Бридж Констракшн ХХК		✓			
31	Броад ХХК		✓			
32	Буд Ундрэм ХХК	✓				
33	Булган Гангат ХХК	✓				

А. Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлсэн компаниуд			Б.Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлээгүй компаниуд			
№	компани	Ашигт малтмалын олборлолтын компани	Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлэх байсан боловч ирүүлээгүй компаниуд	Ашигт малтмалын хайгуулын компани	Газрын тосны компани	Ураны хайгуулын компани
34	Бумбат ресорсес ХХК			✓		
35	Бумбат ХХК	✓				
36	Бэрх Уул ХК	✓				
37	Бэрх ресорсиз ХХК			✓		
38	Бэрэн групп ХХК		✓			
39	Бэрэн майнинг ХХК		✓			
40	Вантаже ХХК		✓			
41	Вояжер Голд ХХК			✓		
42	Галакси майнинг монголиа ХХК			✓		
43	Ган-Илч ХХК		✓			
44	Гацуурт ХХК		✓			
45	ГБНБ ХХК	✓				
46	Геосан ХХК			✓		
47	Гоби Коул энд Энержи ХХК		✓			
48	Гоби эксплорэйшн ХХК			✓		
49	Гоби энерги партнерс ХХК				✓	
50	Голден Крос ХХК			✓		
51	Голден сий петролиум ХХК				✓	
52	Гранд монтана майнинг ХХК		✓			
53	Гурван төхөм ХХК	✓				
54	Дархан борхужир ХХК		✓			
55	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	✓				
56	Дархан шар бүрд ХХК		✓			
57	Дацан трейд ХХК	✓				
58	Доншен Петролиум ХХК		✓			
59	Дөчин Дэлгэрэх ХХК			✓		
60	Дун Юань ХХК	✓				
61	Дун-Эрдэнэ ХХК	✓				
62	Дүншли ХХК		✓			
63	Жадо замбала ХХК			✓		
64	Жинхуа орд ХХК	✓				
65	Жотойн бажууна ХХК	✓				
66	Жөн Юан ХХК	✓				
67	Занаду коппер Монголиа ХХК			✓		

А. Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлсэн компаниуд			Б.Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлээгүй компаниуд			
№	компани	Ашигт малтмалын олборлолтын компани	Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлэх байсан боловч ирүүлээгүй компаниуд	Ашигт малтмалын хайгуулын компани	Газрын тосны компани	Ураны хайгуулын компани
68	Зараяа холдингс ХХК					✓
69	Зє Юу Э ХХК		✓			
70	Зон Хэн Юу Тиан ХХК				✓	
71	Зуун найман суврага ХХК		✓			
72	Инг Хө ХХК		✓			
73	Их Говь Энержи ХХК		✓			
74	Их Тохойрол ХХК		✓			
75	Казиоп Контакт ХХК		✓			
76	Капкорп монголиа ХХК				✓	
77	Кожеговь ХХК					✓
78	Кэй Ви Пи ХХК		✓			
79	Лутчулуу ХХК	✓				
80	Магнай трейд ХХК				✓	
81	Макс Импекс ХХК		✓			
82	Мандал-Алтай групп ХХК		✓			
83	Марко Поло ХХК	✓				
84	Мо Эн Ко ХХК	✓				
85	Могол интернэшнл ХХК			✓		
86	Монвольфрам ХХК	✓				
87	Монгол алтай ресорсез ХХК			✓		
88	Монгол Газар ХХК		✓			
89	Монгол метал майнинг ХХК		✓			
90	Монголболгаргео ХХК	✓				
91	Монголросцветмет ХХК	✓				
92	Монголчех металл ХХК	✓				
93	Монголын Алт МАК ХХК	✓				
94	Мондулаан трейд ХХК		✓			
95	Монлаа ХХК	✓				
96	Монполимет ХХК	✓				
97	Мөнх ноён суврага ХХК	✓				
98	НАБД ХХК	✓				
99	Нарантуул трейд ХХК		✓			
100	НК ХХК	✓				
101	Нордвинд ХХК		✓			
102	Одод Гоулд ХХК	✓				

А. Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлсэн компаниуд			Б.Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлээгүй компаниуд			
№	компани	Ашигт малтмалын олборлолтын компани	Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлэх байсан боловч ирүүлээгүй компаниуд	Ашигт малтмалын хайгуулын компани	Газрын тосны компани	Ураны хайгуулын компани
103	Олова ХХК	✓				
104	Олон овоот гоулд ХХК		✓			
105	ОНТРЭ ХХК		✓			
106	Орд Талст ХХК		✓			
107	Орчлон констракшн ХХК		✓			
108	Очир төв ХХК	✓				
109	Очир Ундраа ХХК		✓			
110	Оюу толгой ХХК	✓				
111	Өрмөн-Уул ХХК	✓				
112	Өү Жи Си Эйч Эл ХХК			✓		
113	Петро матад ХХК				✓	
114	Петрочайна дачин тамсаг ХХК				✓	
115	Полоресорсез-Пибоди винсвей ресорсиз ХХК		✓			
116	Резевоир Монголиа ХХК			✓		
117	Рео ХХК	✓				
118	Рэдхил Монголиа ХХК	✓				
119	Самтан Морес ХХК			✓		
120	Сансарын геологи хайгуул ХХК				✓	
121	Сауд Гоби блэйк гоулд ХХК			✓		
122	Саусгоби сэндс ХХК	✓				
123	Сентерра гоулд монголиа ХХК			✓		
124	Си өү эй эл ХХК	✓				
125	Си Си Эм ХХК			✓		
126	Си Эм Кэй Ай ХХК	✓				
127	Сонор Трейд ХХК	✓				
128	Суурь ХХК		✓			
129	Сэрүүн Сэлбэ ХХК		✓			
130	Таван толгой транс ХХК			✓		
131	Тавантолгой ХК	✓				
132	Талын шигтгээ ХХК		✓			
133	Терра Энержи ХХК			✓		
134	Ти Би И ХХК			✓		
135	Тэгштплант ХХК		✓			
136	Тэн Хун ХХК	✓				

А. Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлсэн компаниуд			Б.Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлээгүй компаниуд			
№	компани	Ашигт малтмалын олборлолтын компани	Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлэх байсан боловч ирүүлээгүй компаниуд	Ашигт малтмалын хайгуулын компани	Газрын тосны компани	Ураны хайгуулын компани
137	Тэсо ХХК			✓		
138	Тэфис майнинг ХХК			✓		
139	Улзгол ХХК	✓				
140	Ууган илч ХХК		✓			
141	Уулс Заамар ХХК		✓			
142	Фокус метал майнинг ХХК		✓			
143	Фрийгүүд эрин ХХК			✓		
144	Фэнчун Интернэшнл ХХК			✓		
145	Хангад эксплорэйшн ХХК	✓				
146	Ханги Проспектинг ХХК			✓		
147	Ханги хүдэр ХХК			✓		
148	Хар Тарвагатай ХК	✓				
149	Харанга Хүдэр ХХК			✓		
150	Хера Инвестмент			✓		
151	Хонгор Хангайн Эрдэнэс ХХК			✓		
152	Хотгор шанага ХХК	✓				
153	Хөх төр ХХК		✓			
154	Хуади куонез ХХК			✓		
155	Хургатай Хайрхан ХХК		✓			
156	Хүрээ дэл ХХК		✓			
157	Хүслэмж ХХК	✓				
158	Хэлтрэгэ ХХК		✓			
159	Цайртминерал ХХК	✓				
160	Цементшохой ТӨХК		✓			
161	Централ эйшиан цемент ХХК		✓			
162	Централ Эшиа Майнинг ХХК		✓			
163	Цэвдэг ХХК	✓				
164	Цэнгэг- Орог ХХК		✓			
165	Цэцэнс майнинг энд энерги ХХК		✓			
166	Чандмань тал ХХК		✓			
167	Чинхуа МАК нарийн сухайт ХХК	✓				
168	Шан Лун ХХК	✓				
169	Шанжин орд ХХК	✓				
170	Шар нарст ХХК	✓				
171	Шарын гол ХХК	✓				

А. Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлсэн компаниуд			Б.Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлээгүй компаниуд			
№	компани	Ашигт малтмалын олборлолтын компани	Нөхөн сэргээлтийн мэдээ ирүүлэх байсан боловч ирүүлээгүй компаниуд	Ашигт малтмалын хайгуулын компани	Газрын тосны компани	Ураны хайгуулын компани
172	Шианганюнтун ХХК		✓			
173	Шивээ овоо ХК	✓				
174	Шинь шинь ХХК	✓				
175	Шинэ азиа Майнинг групп ХХК			✓		
176	Шинэ Илион Нэн Юань ХХК			✓		
177	Шинэ лонгда ХХК	✓				
178	Шинэ Шивээ ХХК			✓		
179	Шэйман ХХК		✓			
180	Эж Бaley ХХК		✓			
181	Эй Пи И Экс Пи Ар Өү ХХК		✓			
182	Эйч Эм Эм Би ХХК			✓		
183	Эм Жи Би ХХК		✓			
184	Эм Пи Эйч Си Эл ХХК			✓		
185	Эм Си Жи Ти ХХК		✓			
186	Эм Си Ти Ти ХХК	✓				
187	Эм Эм Ар Ай ХХК		✓			
188	Эмээлт майнз ХХК					✓
189	Эн Пи Ай ХХК		✓			
190	Энержиресурс ХХК	✓				
191	Эрдэнэ Монгол ХХК			✓		
192	Эрдэнэдалай Коул ХХК			✓		
193	Эрдэнэжас ХХК			✓		
194	Эрдэнэс МГЛ ХХК			✓		
195	Эрдэнэс Таван толгой ХК	✓				
196	Эрдэнэт үйлдвэр ХХК	✓				
197	Эрэл ХХК	✓				
198	Эс Би Эф ХХК			✓		
199	ЭСТО ХХК		✓			
200	Юниверсал Ресорсиз ХХК			✓		

БОНХЯ-аас авсан мэдээгээр 2012 тайлангийн нэгтгэлд хамрагдсан нэр бүхий 45 компани 50 хувийн урьдчилгаанд 1,413,848 мянган төгрөгийг Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн. Харин дээрх нэр бүхий компаниудаас Мондулаан трейд ХХК 2011 онд төвлөрүүлсэн төлбөрөөсөө 15,700.0 мянган төгрөгийг буцаан авсан байна. Дэлгэрэнгүйг доорхи хүснэгтээс үзнэ үү.

№	Огноо	Компани нэр	Орлого (мянган төгрөг)	Зарлага (мянган төгрөг)
1	06/02/2012	Мондулаан трейд ХХК	-	15,700
2	11/01/2012	Олон овоот гоулд ХХК	12,000	
3	12/01/2012	Бороо гоулд ХХК	170,500	
4	25/01/2012	Дархан төмөрлөгийн үйлдвэр	46,750	
5	31/01/2012	Шан лун ХХК	2,000	
6	03/02/2012	Монголын алт мак ХХК	720	
7	03/02/2012	НК ХХК	925	
8	07/02/2012	Гурван төхөм ХХК	3,100	
9	10/02/2012	Тэн хун ХХК	14,850	
10	15/02/2012	Мон лаа ХХК	2,000	
11	17/02/2012	Эсто ХХК	100	
12	27/02/2012	Гоби энэржи партнэрс ХХК	24,508	
13	13/03/2012	Мөнх ноён суврага ХХК	100,000	
14	14/03/2012	МОЭНКО ХХК	84,918	
15	20/03/2012	Очиртөв ХХК	3,035	
16	30/03/2012	Монголын алт мак ХХК	14,000	
17	02/04/2012	Бэрэн Майнинг ХХК	11,000	
18	04/04/2012	ШИАНГАНЮНТУН ХХК	7,500	
19	16/04/2012	Шанжин орд ХХК	15,000	
20	17/04/2012	Монгол чех металл ХХК	1,500	
21	18/04/2012	Бумбат ХХК	24,719	
22	18/04/2012	Алтан Дорнод монгол ХХК	29,891	
23	18/04/2012	Лут чулуу ХХК	25,000	
24	20/04/2012	Саусгоби сэндс ХХК	216,900	
25	19/04/2012	Оюу толгой ХХК	170,080	
26	23/04/2012	Бэрх уул ХХК	6,375	
27	25/04/2012	Оюу толгой ХХК	13	
28	25/04/2012	Дунь юань ХХК	6,500	
29	26/04/2012	Эрдэнэс таван толгой ХК	25,742	
30	01/05/2012	Петро матад ХХК	8,538	
31	03/05/2012	Эм Си Ти Ти ХХК	6,000	
32	09/05/2012	Бадмаараг Хаш ХХК	192,455	
33	11/05/2012	Оюу толгой ХХК	13	
34	16/05/2012	Капкорп монголиа ХХК	35,481	
35	16/05/2012	ЭН ПИ АЙ ХХК	26,280	
36	24/05/2012	Бэрх уул ХХК	4,400	
37	30/05/2012	Би Эйч Эм ХХК	2,099	
38	05/06/2012	Сансарын геологи хайгуул ХХК	23,616	
39	05/06/2012	Сансарын геологи хайгуул ХХК	23,616	
40	04/06/2012	Би Эйч Эм ХХК	2,600	
41	14/06/2012	Өрмөн Уул ХХК	2,500	
42	13/06/2012	Жинхуа орд ХХК	6,000	
43	25/06/2012	Жотойн бажууна ХХК	4,000	
44	26/07/2012	Булган гангант ХХК	7,500	
45	07/08/2012	Баян эрч ХХК	5,150	
46	15/08/2012	Хотгор шанага ХХК	10,000	
47	21/08/2012	Шинэлонгда ХХК	7,500	
48	04/09/2012	Марко Поло ХХК	6,552	
49	05/09/2012	Дацан трейд ХХК	3,200	
50	17/09/2012	Анхай интернэшнл ХХК	10,350	
51	16/10/2012	Мондулаан трейд ХХК	2,000	
52	27/11/2012	Цемент үйлдвэр ХХК	4,372	
Нийт			1,413,848	15,700

7.3 Орон нутагтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн судалгаа

Уул уурхайн компаниудаас Орон нутгийн ЗДТГ-тай байгуулсан Хамтран ажиллах гэрээ, ус ашиглах гэрээ, газар ашиглах болон бусад гэрээ контрактыг тодруулахад 149 компани орон нутагтай байгуулсан гэрээ байдаг, 51 компани энэ төрлийн гэрээ байхгүй гэж тайлбарласан. Дэлгэрэнгүйг хавсралт 10 үзнэ үү,

Нэгтгэл тайлангийн явцад холбогдох гэрээнүүдийг аудитад хамруулахыг хүсч утсаар болон майл электрон хаягаар удаа дараа хандсан боловч 32 компани давхардсан тоогоор 132 гэрээ өгсөн. Гэрээний хураангуй дараах байдалтай байна. Дэлгэрэнгүйг хавсралт № 11-д харуулав.

Д.д	Гэрээний утга	Гэрээ хийсэн компанийн тоо (давхардсан тоогоор)	Хийсэн гэрээний тоо	Гэрээнд хамрагдсан орон нутаг (давхардсан тоогоор)
1	Байгаль орчныг хамгаалах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай	4	4	4
2	Нийгмийн хариуцлагын чиглэлээр хамтран ажиллах гэрээ	11	22	19
3	Ус ашиглах гэрээ	16	21	17
4	Газар эзэмшүүлэх гэрээ	17	83	16
5	Бусад гэрээ	2	2	2
Бүгд		50	132	58

8. ЗӨВЛӨМЖҮҮД

8.1 Нэгтгэл хийхийн өмнө цар хүрээ тогтоох судалгааг нарийвчлан хийгээгүй байна

Материаллаг байдал

2011 онд гарсан ОУИТБС-ын дүрэмд зааснаар ОУИТБС-ын Олон талын оролцоот Ажлын хэсэг нь материаллаг байдлын тодорхойлолтын талаар зөвшилцөлд хүрсэн байх шаардлага тавигддаг. 2010 онд хийгдсэн аудитын нэгтгэл нь Үндэсний зөвлөлөөс 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр батлан гаргасан материаллаг түвшин дээр үндэслэн хийгджээ. 2013 онд аудитын нэгтгэлийн үйл ажиллагаа явагдсан ч тухайн ороны уул уурхайн салбарын орчинд нийцүүлэн материаллаг байдлыг шинэчлээгүй байна. Энэхүү нөхцөл байдал нь материаллаг бус татвар болон уул уурхайн бус компаниудыг нэгтгэлд хамруулахад хүргэжээ.

Материаллаг байдлыг тодорхойлон гаргахад ашигласан арга зүй болон хандлага нь тодорхойгүй байна. Ажлын хэсгээс аудитын нэгтгэлд хамруулах олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон татварын төрлийг сонгон авах үндэслэлийг тодорхой тогтоон гаргаагүй. ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдөр болсон хуралдаанаар компаниудаас Засгийн газарт 10,000,0 мянган төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамж төлсөн бүх компани тайлан гаргаж байхаар шийдвэрлэсэн. Улмаар Үндэсний зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар 2012 онд ОУИТБС-ын тайлан гаргасан компаниудаас 40,000,0 мянган төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамж төлсөн компаниудын тайланг аудитын нэгтгэлд хамруулж байхаар шийдвэрлэсэн. Гэвч аудиторуд ОУИТБС-ын тайланд хамаарах нийт орлогыг тухайн салбараас орсон нийт орлоготой харьцуулан гаргах боломжгүй байна. Энэхүү тайлангийн 3.6 дугаар хэсэг дээр аудитын нэгтгэлийн үйл ажиллагааг эхлүүлэхэд байсан мэдээллийг ашиглан хамрах хүрээг тогтоох оролдлогыг хийсэн. Гэвч Татварын Ерөнхий Газраас гаргаж өгсөн мэдээллийн баталгаа муу, зохистой бус байснаас хамааран энэхүү дүн шинжилгээ нь алдаатай гарч байна.

Мөн 2012 оны аудитын нэгтгэлд хамруулах компанийг сонгохдоо нэгтгэлд хамруулах босго болох 40.000,0 мянган төгрөгийн босгыг даган мөрдөөгүй байна. Сонгогдсон компаниудаас нийт 4 компанийн төлсөн татвар, төлбөр, хураамжийн хэмжээ энэхүү босго мөнгөн дүнд хүрээгүй байна.

Олборлох үйлдвэрлэлийн компаниудын талаар

Татварын Ерөнхий Газраас хүлээн авсан тайланд дурдсанаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 1829 компани байгаа бөгөөд эдгээр компаниуд татвар, төлбөр, хураамжийг Засгийн газарт төлсөн байна. Нийт төлсөн татвар, төлбөр, хураамжийн хэмжээ нь 40.00,0 мянган төгрөгийн босгыг давсан байх ёстой хэмээх шалгуураар авч үзвэл нийт 471 компани энэхүү аудитын нэгтгэлд хамрагдах ёстой байна. Үндэсний зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 200- 300 олборлох үйлдвэрлэлийн компани байна хэмээн тогтоожээ. Үүнд үндэслэн Үндэсний зөвлөлийн гишүүд 2012 оны аудитын нэгтгэлд 200 компанийг хамруулахаар тогтсон байна.

Аудитын нэгтгэлд хамрагдсан 200 компанийн 7 нь олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшдэг байна. Эдгээр 7 компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд харууллаа:

№	Компани	Бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны төрөл	Байрлал	
				Аймаг, нийслэл	Сум, дүүрэг
26	Билгүүнтрөйд ХХК	2088967	Барилга угсралт	Улаанбаатар	Баянгол
30	Бридж Констракш ХХК	2593009	Барилга угсралт, гадаад худалдаа	Улаанбаатар	Баянзүрх
81	Макс Импекс ХХК	2057573	Худалдаа	Улаанбаатар	Баянзүрх
107	Орчлон Констракшн ХХК	2747804	Барилга угсралт	Улаанбаатар	Сүхбаатар
130	Таван толгой транс ХХК	5000505	Тээвэр	Улаанбаатар	Хан-Уул

№	Компани	Бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны төрөл	Байрлал	
				Аймаг, нийслэл	Сум, дүүрэг
150	Хера Инвестмент ХХК	2787687	Гадаад худалдаа	Улаанбаатар	Баянгол
199	ЭСТО ХХК	2861224	Барилга угсралт	Улаанбаатар	Сүхбаатар

Ямар нэгэн компани тусгай зөвшөөрөл эзэмшиж байна гэдэг нь тухайн компани олборлох үйл ажиллагааг явуулж байна гэсэн үг биш юм. Үүнээс үүдэн тэдгээр компаниудыг аудитын нэгтгэлд хамруулахаас өмнө тэдний үйл ажиллагаан дээр нарийвчилсан дүн шинжилгээ хийж байх шаардлагатай.

Орлогын урсгалын талаар

2012 оны аудитын нэгтгэлд хамруулахаар сонгосон орлогын урсгал төрлийн хувьд ОУИТБС-ын тайлангуудын талаарх илүү сайн ойлголтыг бий болгохын тулд төлбөр болон бусад тусламж дэмжлэг зэргийг дахин хянан үзэж, шинэчлэн боловсруулахыг санал болгож байна. Зарим төрлийн орлогыг (Жишээ нь хандив тусламжийг) заавал тайлагнах ангилалд хамруулсан ч бодит байдал дээр энэ нь сонголтот төлбөр бөгөөд үүнийг “заавал” хэмээх ангилалд хамруулж болохгүй. Мөн хэд хэдэн төрлийн төлбөрийг (жишээ нь тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрлийн төлбөр зэргийг) сайн дурын төлбөрийн ангилалд хамруулсныг цохон дурдаж байна. Эдгээр төлбөрүүд нь “заавал” хэмээх ангилалд хамрагдах бөгөөд энэ талаар Монгол улсын хэд хэдэн хууль тогтоомжид тусгагдсан байна. Эдгээр төлбөрүүдийг ийнхүү буруу ангилалд хамааруулсан нь тайлан гаргаж буй компаниуд маягтыг бөглөх үедээ буруу мэдээлэл гаргаж өгөхөд хүргэж байна.

Мөн олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс төрийн байгууллагуудад (яам, агентлаг, аймаг нийслэл болон сум дүүргийн захиргаа болон бусад төрийн байгууллагууд) мөнгөн бус хэлбэрээр өгсөн хандив тусламжийг нэгтгэлд хамруулах шаардлага бидэнд тавигдсан. Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс олон төрлийн мөнгөн бус хэлбэрийн хандив тусламжийг (жишээ нь тоног төхөөрөмж, баяр наадам ивээн тэтгэх, хурал уулзалт зохион байгуулах гэх мэт) төв болон орон нутгийн төрийн байгууллагуудад өгч байна. Энэхүү ангиллын дагуу яг ямар зүйлийг тайлагнах ёстой талаарх ойлгомжтой боловсруулан гаргасан тодорхойлолтгүйгээр олборлох үйлдвэрлэлийн компаниуд нь төрийн хувьд бодитоор орлого болж орсон гэж үзэх боломжгүй хандив тусламжийг тайлагнаж байхад хүргээд байна. Энэхүү нөхцөл байдал нь төрийн зүгээс хүлээн авсан дүн нь салбарын зүгээс тайлагнаснаас илүү гарахад хүргэнэ.

Үүнээс гадна мөнгөн бус хэлбэрээр өгсөн хандив тусламжийг нэгтгэлд хамруулах нь тухайн орлогыг үнэлэх аргачлалууд өөр өөр байдгаас хамааран томоохон хэмжээний зөрүүг үүсгэж болох юм. Үүнтэй холбоотойгоор тайлангийн маягтуудад ямар нэгэн тодорхой зааварчилгаа тусгагдаагүй байна.

Мөн тайлангийн маягтууд нь компанийн гаргасан зардал болох хөрөнгө оруулалтын зардал, ажилчдын сургалтад зарцуулсан зардал, чадавхыг бэхжүүлэх чиглэлийн зардал, геологи хайгуулын зардал, байгаль орчныг хамгаалах зардал, гамшгаас сэргийлэх зардал зэргийг багтаасан байна. Эдгээр зардлуудыг Монгол улсын Засгийн газрын хүлээн авсан орлого хэмээн үзэх боломжгүй тул ОУИТБС-ын хамрах хүрээнд харьяалагдахгүй юм.

Тайлангийн маягтуудад дурдсан орлогын урсгал төрлүүд нь нөхөн төлбөр, торгууль болон бусад төлбөр хэмээх хэд хэдэн ерөнхий төлбөрийг багтаасан байна. Ийм төрлийн өргөн хүрээг хамарсан ерөнхий ангиллаас татгалзах нь зөв болохыг зөвлөж байна. Учир нь үүнээс үүдэн буруу ойлгон, тайлагнах явдал гарч болох тул тайлан гаргаж буй компаниудад зориулсан зааварчилгааг төлбөр тус бүрээр нь гаргаж өгсөн байх шаардлагатай. Нөхөн төлбөр, торгууль болон бусад төлбөр нь аудитын нэгтгэлийн үеэр олж илрүүлсэн зөрүүнд өндөр хувь хэмжээг эзэлж байна.

Тайлангийн маягтуудын талаар

Монголын ОУИТБС нь 2012 оны аудитын нэгтгэлийг нийт 7 маягтаар гаргаж нэгтгэсэн байна. Бидний өмнөх туршлагаас харвал үйл ажиллагаа нэг бүрт (ашигт малтмал олборлох, хайгуул, газрын тосны хайгуул, олборлолт) зориулсан тусдаа маягтыг гарган ашиглах шаардлагагүй байдаг. Ихэнх татвар нь бүх компаниудын хувьд түгээмэл хэрэглэгдэх татвар байдаг тул бүх татварыг нэг маягтаар төвлөрүүлэх нь практикт илүү нийцэх юм. Ингэснээр олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон Засгийн газрын харъяа байгууллагууд нь тухайн маягтад байгаа зөвхөн өөрийн хамаарах хэсгийг (татвар/орлого) бөглөж болно.

Тайлан гаргаж буй байгууллагууд нь өөрсдийн тайлантай хамт төлбөр хийсэн хугацаа, дүн зэрэг төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг цуг ирүүлээгүй байна. Тэд зөвхөн татвар нэг бүрээр төлсөн жилийн нийт дүнг тайлагнаж байна. Төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл нь аудитын нэгтгэлийн ажилд зайлшгүй шаардлагатай баримт бичиг юм. Бид бүх компани болон төрийн байгууллагуудад аудитын нэгтгэл эхлэхэд дэлгэрэнгүй мэдээлэл гарган өгөх хүсэлтийг явуулсан. Эдгээр байгууллагууд нь анх тайлан өгөхөд өөрийн тайлангийн хамтаар холбогддог төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг хамтад нь ирүүлсэн бол илүү үр дүнтэй байж, цаг хугацаа хэмнэх боломжтой байсан.

Мөн хэд хэдэн олборлох үйлдвэрлэлийн компаниуд 2013 онд батлагдсан шинэчлэгдсэн маягтаар бус ҮСХ-ны дарга болон Сангийн сайдын хамтарсан 2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн тушаалаар батлагдсан хуучин маягтыг ашиглан тайлангаа бэлтгэсэн.

Одоо ашиглагдаж буй тайлангийн маягтуудад тухайн төлбөрийг ямар төрийн байгууллага хүлээн авч буйг харуулах заалт, үзүүлэлтийг багтаагаагүй байна. Төлбөр хүлээн авагч талуудын тоо олон тул компанийн тайлан дээр тухайн төлбөрийг хүлээн авсан төрийн байгууллагыг мөн дурдаж байх нь зүйтэй. Жишээ нь НӨАТ-ыг Татварын алба болон Гаалийн ерөнхий газрын аль алинд нь төлж болох тул тухайн төлбөрийг хүлээн авагч этгээдийг дурдалгүйгээр тайлан гаргаснаар тухайн тайлагнасан дүн нь аудитын нэгтгэл хийх ажлыг ихээхэн хүндрүүлж байна.

Монгол улс дахь олборлох үйлдвэрлэлийн хэмжээ болон эрх зүй, татварын орчинд байгаа асуудлуудыг харгалзан бидний зүгээс аудитын нэгтгэл хийж эхлэхийн өмнө Хамрах хүрээг тогтоох судалгааг хийж, ингэснээр Үндэсний зөвлөл нь материаллаг байдлын босго, томоохон хэмжээний төлбөрүүд, өндөр ач холбогдол бүхий олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагууд, тайлангийн маягт зэрэг дээр зөвшилцөлд хүрэх боломжийг хангаж байхыг онцгойлон зөвлөмж болгож байна. Энэ нь цаашид суралцах боломжийг ханган, улмаар дараа дараагийн нэгтгэлийн хүрээнд шинэчлэгдэн, сайжруулж хэрэглэх боломжийг бий болгох юм. Хамрах хүрээг тогтоох судалгааг ОУИТБС-ын шинэ журмаар (2013) заавал хийж байхыг шаардах болсон.

Хамрах хүрээг тогтоох судалгааны хувьд Ажлын хэсэг нь доорх зүйлс дээр анхаарлаа хандуулах шаардлагатай байна:

- *Хамрах хүрээ тогтоох судалгааг аудитын нэгтгэлээс өмнө хийж, ингэснээр мэдээлэл цуглуулах болон олборлох үйлдвэрлэлийн салбарын үнэлгээг хийхэд зориулсан хангалттай хугацааг гарган өгөх. Энэ нь мөн Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт судалгааны үр дүн дээр дүн шинжилгээ хийн, аудитын нэгтгэл эхлэхээс өмнө шаардлагатай арга хэмжээг авах боломжийг олгоно;*
- *ОУИТБС-ын Олон улсын ажлын алба нь одоогоор Хамрах хүрээ тогтоох судалгааны Гүйцэтгэх ажлын даалгаварын загвар маягтыг боловсруулж байна. Энэхүү баримт бичгийг цаашид улс орнууд дахь Ажлын албадад гарган өгч зааварчилгаа байдлаар ашиглах боломжийг хангах бөгөөд энэхүү Гүйцэтгэх ажлын даалгаварыг ирээдүйд өөрчлөн ашиглахыг зөвлөмж болгож байна.*

8.2 Зарим оролцогч талууд ОУИТБС-ын зарчмуудын талаарх ойлголт жигд биш, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзлэл бага

Аудитын нэгтгэлд хамрагдсан зарим оролцогч талууд (олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагууд) ОУИТБС-ын олон улсын ач холбогдол, Монгол улсын гишүүнчлэлийн талаар ойлголт жигд биш байна. Бодит байдал дээр оролцогч талууд нь Монгол улсад ОУИТБС-ыг удирдаж, хэрэгжүүлж буй бүтэц, хамаарах хууль тогтоомжууд, өөрсдийн үүрэг роль, аудитын нэгтгэлд хамрагдах ёстой эсэх болон өөрсдийн гарган өгч буй мэдээллийн ач холбогдлын талаар мэдлэг хангалтгүй байна. Бидний зүгээс ОУИТБС-ын үйл явц, нэгтгэлийн талаар тухайн талуудын удирдлага, нягтлан бодогч нар, төрийн зарим байгууллагуудын ажилтнуудад тайлбарлах тал дээр ихээхэн цаг зарцуулах шаардлагатай болсон.

Аудитын нэгтгэл эхэлснээс хойш цөөн тооны компаниуд болон Гаалийн ерөнхий газар нь татварын мэдээллийг нууцлал бүхий мэдээлэл учраас гарган өгөхөөс татгалзсаар ирсэн. 2011 оны ОУИТБС-ын дүрмийн 8 дугаар шаардлагын дагуу Засгийн газар нь “Компаниудтай хийсэн гэрээнд буй мэдээллийн нууцлалын тухай заалтуудын хэрэгжилтэд өөрчлөлт оруулан, орлогыг ил тод болгохыг зөшөөрүүлэх замаар ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах”-ыг заасан байдаг. (8-b-v).

Хэдийгээр Монгол улсад сүүлийн 6 жилийн туршид аудитын нэгтгэл хийгдсэн ч оролцогч талуудын үүрэг ролийг тодорхойлсон эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байна. Тайлан гаргах болон нэгтгэл хийх үйл ажиллагааг Сангийн яам болон ҮСХ-оос гаргасан уул уурхайн үйл ажиллагааны тайлан гаргах, ашигт малтмал болон газрын тосны компаниудын үйл ажиллагааг тайлагнах тухай журмаар л зохицуулж байна. Талуудын (төр болон олборлох үйлдвэрлэлийн компаниуд) үүрэг, роль тодорхой бус байгаа тул нэгтгэл хийх ажиллагаа тодорхой хэмжээний хүндрэлүүдтэй тулгарч байна.

Энэхүү нөхцөл байдал нь нэгтгэл хийх үйл явцыг илүү их хүндрэлтэй, ажиллагаатай болгож байна. Нэгтгэлийн үйл ажиллагааны үр дүн нь оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаанаас ихээхэн хамааралтай. 2011 оны ОУИТБС-ын дүрмийн шаардлага 2-д Засгийн газар нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байхаар тусгасан байдаг. Ингэснээр төрийн бүх байгууллагууд Монгол улсын зүгээс ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр гаргаж буй хүчин чармайлтыг сайтар ойлгосон байх юм. Нөгөө талаар 2011 оны ОУИТБС-ын дүрмийн Шаардлага 7-д Засгийн газар нь ОУИТБС-ын хэрэгжилтэд компаниудыг татан оруулах шаардлагыг тусгасан байдаг. Энэ нь олборлох үйлдвэрлэлийн бүх компаниуд ОУИТБС-ын процессыг даган мөрдөж, шаардлагатай тохиолдолд тусламж дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах ёстой хэмээх утгыг илэрхийлж буй юм.

Ажлын хэсэг нь өөрийн мэдээлэл харилцааны стратегийг сайжруулж, ОУИТБС-ын тухай, үүний үүрэг роль, үр дүн мэдлэг олгох нэгдсэн ажлыг зохион байгуулж хамаарах бүх оролцогч талыг идэвхижүүлэх, ОУИТБС-ын үйл явц болон тайлан гаргах шаардлага бүхий байгууллагуудад энэ талаар ойлгуулах чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байхыг зөвлөмж болгож байна (олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагууд).

Тайлан гаргах үүрэг бүхий байгууллагуудыг ОУИТБС-ын бага хурал, семинаруудад урин оролцуулж, ОУИТБС-ын тухай илүү сайн ойлголтуудыг төлөвшүүлж байхыг санал болгож байна. Бид мөн хэвлэл мэдээллээр олон нийтэд хандсан сурталчилгаа мэдээлэл явуулж үүнийг нэгтгэл хийхийн өмнө түгээж, нийтэлж байхыг санал болгож байна.

Мөн одоогоор боловсруулж буй ОУИТБС-ын тухай хуулинд нь ОУИТБС-ын шаардлагын дагуу компаниудын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг тусгахыг санал болгож байна. Тайлан гаргах үүрэг биелүүлээгүй, цаг хугацаанд нь тайлангаа ирүүлээгүй компаниудад арга хэмжээ авахаар тусгах зэргээр үүнийг хийж болно.

8.3 Тайлангийн маягыг оролцогч талууд хангалттай түвшинд бэлтгэн гаргаагүй

Олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагуудын тайлангууд нь хангалттай түвшинд бэлтгэн гаргаагүй болохыг тэмдэглэж байна. Нэгтгэл хийх үед ажиглагдсан хэд хэдэн асуудлын тухай доор дурдлаа:

- Компани болон Засгийн газар нь өгсөн болон хүлээн авсан хандив тусламжийн талаар заавал тайлагнаж байх ёстой (Сангийн сайдын 2010 оны 45 дугаар тушаал). Харин Татварын ерөнхий газрын бэлтгэн гаргасан тайланд цөөн тооны компаниудаас хандив авсан болохыг дурдсан байна;
- Төрийн зарим байгууллагын гаргасан тайланд агаарын бохирдлын төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн торгууль болон мэргэжийн хяналт, Гаалийн ерөнхий газрын нөхөн төлбөр торгууль, Үндэсний аудитын газраас ногдуулсан төлбөр, хөдөлмөр халамжийн байгууллагын болон цагдаагийн байгууллагын хүлээн авсан төлбөрийг тайлагнаагүй байна;
- Төрийн байгууллага нь орон нутгийн мэргэжлийн хяналт болон нийгмийн даатгалын байгууллагад төлсөн төлбөр, хураамжийг тайлагнаагүй байна; мөн
- Компаниудын гаргасан хэд хэдэн тайлан дээр үйлдвэрлэлийн тоо хэмжээний тухай мэдээлэл, тусгай зөвшөөрлийн мэдээлэл болон байршил зэргийг тайлагнаагүй байна.

Энэхүү нөхцөл байдал нь ихээхэн саад бэрхшээл учруулсан бөгөөд учир нь тухайн байгууллагуудын гаргасан мэдээлэл нь ойлгомжгүй байсан юм. Үүнээс үүдэн мөн тухайн тоо баримтыг шалган баталгаажуулах, төлбөрт тодотгол хийх зэрэгт ихээхэн нөөцийг зарцуулах шаардлагатай болсон.

Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь тайлан гаргаж буй байгууллагуудад өөрийнх нь гарган өгч буй мэдээллийн ач холбогдлыг ойлгуулж, эдгээр тайланг бэлтгэн гаргах үйл явцад анхаарал хандуулан ажиллаж байхыг зөвлөмж болгож байна.

Мөн тайлангийн маягуудыг хүргүүлэхээс өмнө сургалт хийж байхыг зөвлөж байна. Энэхүү сургалтаар тайлангийн маягыг бүх талуудад танилцуулан, тайлан бэлтгэхэд зориулсан зааварчилгааг гаргаж өгөх шаардлагатай.

8.4 Эрх зүй, татварын орчин хангалттай бүрдээгүй

Монгол улс дахь эрх зүй, татварын орчин нь хэд хэдэн хязгаарлалтуудтай тулгарч байна. Доор бид эрх зүй, татварын орчныг сайжруулах чиглэлээр Монгол улсын Засгийн газрын анхаарал хандуулах томоохон асуудлуудын талаар дурдсан бөгөөд эдгээрт хандан үйл ажиллагаа явуулснаар орлогыг шалган илрүүлэх болон ил тод болгох боломжтой юм.

Монгол улсад төлбөр тооцооны төвлөрсөн систем дутагдалтай байх

Төрийн байгууллагуудын төлбөр болон орлого төвлөрүүлэлтийг төвлөрсөн бус байдлаар хийж байна. Төрийн авах ёстой татвар, төлбөр, хураамжийг яам, агентлагууд болон орон нутаг цуглуулж байна. ОУИТБС-ын энэ удаагийн болон өмнөх тайлангуудаас харвал ойролцоогоор 100 гаруй төрийн байгууллага татвар, хураамж, төлбөрийг олборлох үйлдвэрлэлийн компаниудаас авч байна. Төрийн зүгээс орлого цуглуулах байгууллагуудын тоо их байгаагийн зэрэгцээ эдгээр төлбөрүүдийг төвлөрүүлэх ямар нэгэн систем байхгүй байна.

Аудитын нэгтгэлийг хийх үед бид уул уурхайн компаниудын зүгээс орон нутгийн төрийн байгууллагуудад төлж буй төлбөрийг татварын албанд тайлагнахгүй байгаа болохыг ажигласан. Түүнчлэн 2010 оны Сангийн сайдын 45 тоот тушаалаар зохицуулж буй хандив тусламжийн тайлан нь төрийн байгууллагуудын тайланд дурдагдаагүй байгаа нь Засгийн газрын түвшинд энэ төрлийн бүртгэл байхгүй болохыг харуулж байна.

Компаниуд нь өөрийн татвар болон хураамжийг төлөхдөө арилжааны банкууд дээрх Төрийн сангийн дансанд төлөх боломжтой ба арилжааны банкууд нь тухайн төлбөрийг Төрийн санд шилжүүлж байна.

Энэхүү нөхцөл байдал нь Засгийн газрын хувьд дутагдалтай талыг бий болгох бөгөөд энэ нь өнөөгийн уул уурхайн салбарын орлого цуглуулах үйл явц, хяналтаас хамаарсан ба эдгээр нь доорх байдалтай байна:

- Уул уурхайн татвар, төлбөр, хураамж цуглуулах үйл явцыг аймаг болон сумын түвшинд төвлөрлийг бууруулсан байдалтай хийдэг;
- Төрийн сангийн онцлог байдал, зарчмуудыг даган мөрддөггүй;
- Төв болон орон нутгийн төрийн байгууллагуудын хооронд уул уурхайн орлогыг судлах, хянах тал дээр зохицуулалт муу; болон
- Уул уурхайн компаниудын төлж буй татварын хэмжээнээс үүдэн иж бүрэн хяналт, нэгтгэл хийх үйл явц байхгүй.

Монгол улсын татвар хураалтын системийг эргэн харж өөрчлөлт оруулах нь олборлох салбарын орлогыг хянах, ил тод байдлыг сайжруулах болон орлогыг илрүүлэх болон хянах байдлыг сайжруулахад ихээхэн чухал ач холбогдолтой болно.

Татвар төлөгчийн нэгдсэн дугаар байхгүй

Монгол улсын хувьд татвар төлөгч нарт олгосон татвар төлөгчийн дугаар байхгүй байна. Хийгдэж буй төлбөрүүд нь ихэнхдээ компанийн бүртгэлийн дугаарыг ашиглан хийгдэж байна. Үүнээс үүдээд компани нэг бүрээр төлсөн татварыг гаргах нь хүндрэлтэй болж байгаа бөгөөд зарим тохиолдолд нэг компанийн өмнөөс өөр компани төлбөр төлдөг байдал ажиглагдаж байна. Хэд хэдэн тохиолдолд зарим компанийн өмнөөс татварыг нь толгой компани эсвэл туслан гүйцэтгэгч нь төлөх, эсвэл засгийн газрын бүртгэл дээр туслан гүйцэтгэгч нарыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нэрээр бүртгэсэн зэрэг асуудлууд байна.

Мөн толгой компани болон охин компани нь тусдаа аж ахуйн нэгж хэмээн бүртгэгдсэн байдаг. Харин нэгтгэлийн ажлын хувьд компани нэг бүр тусдаа тайлан гарган ирүүлэх шаардлагатай. Гэхдээ толгой болон салбар компани нь хоёул тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол төрийн байгууллагуудаас гаргасан тайлан нь группын хэмжээний нэг мөнгөн дүнг тусгасан буй бөгөөд аж ахуйн нэгж бүрээр задлаагүй байна.

Мөн Ашигт малтмалын газар уул уурхайн компаниудиа авсан орлогыг бүртгэхдээ бүртгэлийн дугаарыг нь ашиглахгүй байна. Хүлээн авсан баримтууд нь зөвхөн компанийн нэрээр байна. Хэд хэдэн тохиолдолд төлбөрийг буруу компанийн нэрээр оруулсан байгааг бид ажигласан бөгөөд компанийн нэрийг буруу бичсэн эсвэл ижил төстэй нэрийг хольж сольсон байна. Мөн зарим төлбөрийг компанийн нэрээр бус харин төлбөр хийсэн хүний нэрээр бүртгэсэн нь харагдаж байна.

Давтагдашгүй нэг дугаарыг төрийн бүх байгууллага хүлээн авсан татвараа тайлагнах болон хуваарилахад ашиглахгүй байгаагаас үүдэн тухайн төлбөрийн талаар мэдээлэл авах үйл явцыг ихээхэн хүндрэлтэй болгож байна. Энэхүү нөхцөл байдал нь компани болон төрийн байгууллагуудын хоорондын тайлан дээр ихээхэн зөрүү үүсгэж байна.

Монгол улсын Засгийн газар нь бүртгэлийн давтагдашгүй дугаарыг бүх төрийн байгууллага дээр ашиглан, татвар төлөгчийн нэрийг хүлээн авсан татвар, төлбөрөө бүртгэхэд ашиглахаас зайлсхийхийг санал болгож байна. Мөн бидний зүгээс Засгийн газар нь бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдэд татвар төлөгчийн дугаар олгон ашиглахыг зөвлөж байна.

8.5 Тайлангууд нь аудитаар баталгаажуулж байх

Гарган өгсөн тайлангуудын чанар болон бидний хийсэн ихээхэн хэмжээний тодруулгын хүрээнд авч үзвэл гарган өгсөн тайлангууд нь аудитаар баталгаажсан тайлан дээр суурилсан байна гэх баталгааг бид олоогүй болно. Зөвхөн Резевоир Монголиа ХХК-ийн тайланг л хөндлөнгийн бие даасан аудитор баталгаажуулсан байлаа.

Монгол улсад хэрэгжиж буй энэхүү санаачилгын хувьд олборлох үйлдвэрлэлийн компаниудын гаргасан мэдээлэл болон төрийн байгууллагаас гаргасан мэдээлэл нь баталгаатай байх шаардлагатай бөгөөд үүнийг ОУИТБС-ын Эх сурвалж болон дүрмийн шаардлага 12 болон 13-д заасны дагуу олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагууд нь баталгаажсан мэдээлэл явуулж байх нь ихээхэн чухал юм.

Ажлын хэсэг нь доор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх замаар шаардлагатай ажлыг хийхийг санал болгож байна:

- *Оролцогч талуудад ОУИТБС-ын үйл явцын энэхүү элементийн ач холбогдлын талаар ойлгуулан таниулах; болон*
- *Мэдээллийг баталгаажуулсан байх хугацааг гарган тогтоох. Хамрах хүрээг тогтоох судалгаа нь тайлан гаргаж буй байгууллагуудын мэдээллийн найдвартай байдлыг хэрхэн хангах талаар судлан, тусгах шаардлагатай.*

8.6 Мэдээлэл, харилцаа холбоог сайжруулах

Монголын ОУИТБС-ын вебсайт дээр буй мэдээллийг Англи хэлэнд системтэйгээр орчуулаагүй байгаа бөгөөд жишээ нь ҮЗ-ийн хурлын тэмдэглэл, хууль, тайлангуудын тойм, мэдээ зэрэг багтаж байна.

Монголын ОУИТБС-ын вебсайт нь Монгол болон Англи хэл дээр байж, үүн дээр гаргасан бүх мэдээллийг Англи хэл дээр оруулан, мэдээллийг олон талуудад илүү сайн хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

8.7 ОУИТБС-ын мэдээллийн сан дутмаг

Өнөөгийн байдлаар Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь тухайн салбарт ажиллаж буй бүх компанийн тухай бүрэн хэмжээний иж бүрэн мэдээллийн сангүй байна. Энэ нь тухайн салбарт ажиллаж буй компаниудыг хариуцсан төрийн байгууллагуудтай албан ёсны харилцаа холбоо байхгүйтэй холбоотой байна.

Зарим тохиолдолд олборлох үйлдвэрлэлийн компаниудтай холбоо тогтооход тэдний талаар мэдээлэл байхгүй буй нь ихээхэн хүндрэлийг үүсгэж байсан. Зарим тохиолдолд компанийн нэрийг Монголоор өөр өөрөөр дурдсан байгаа нь тэднийг олоход хүндрэл үүсгэж байна.

Юуны өмнө Ажлын алба нь энэхүү нэгтгэлийн дараагаар өөрийн мэдээллийн санг бий болгохыг зөвлөмж болгож байна. Ажлын алба нь төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хамаарах мэдээллийг байнга авч, өөрийн мэдээллийн санг байнга баяжуулж байх шаардлагатай. Ингэснээр тухайн салбарт шинээр орж буй компанийг бүртгэн авч, тухайн этгээд тусгай зөвшөөрөл авсан даруйд нь мэдээллийн санд оруулах боломжтой болох юм. Төрийн байгууллагуудтай хамтран мэдээллээ улирал тутамд хянаж үзэж, компанийн жагсаалтыг хянаж байхыг санал болгож байна.

Өмнө нь нэгтгэлд хамрагдаж байсан компани болон төрийн байгууллага бүр нь хариуцсан нэг хүнийг томилон, ОУИТБС-ын тайланг хариуцан иж бүрнээр гаргаж байх шаардлагатай бөгөөд компаниуд нь тухайн хариуцах хүний нэр, хаягийг ОУИТБС-д мэдэгдэх шаардлагатай.

8.8 Ажлын албаны чадавхыг бэхжүүлэх

Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь гурван хүнтэй бөгөөд үүнд Зохицуулагч, Мэдээлэл харилцааны ажилтан болон Санхүү захиргааны туслах ажилтан багтаж байна. Бидний үзэж буйгаар Ажлын албаны бүтэц нь ихээхэн сул, хийж буй ажлын хэмжээ, ОУИТБС-ын үйл явцын хүрээнд тулгарч буй асуудлын хүрээнд хэт жижиг байна. 2013 онд ОУИТБС-ын шинэ журам гарснаар цаашид тулгарах сорилтууд болон тавигдах шардлагууд ихээр нэмэгдэх тул, Ажлын албаны бүтцийг бэхжүүлэх үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно.

Доор дурдсан шалтгаануудын улмаас ОУИТБС-ын бүтцийг бэхжүүлэх шаардлагатай болох зөвлөмжийг өгч байна:

- *Хууль зүйн ажилтан: Монгол улс дахь ОУИТБС-ын үйл явцын эрх зүйн орчны асуудлыг хариуцан ажиллах, үүрэг роль нь татварын зохицуулалтууд болон салбарын эрх зүйн орчныг судлах, үүнд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах.; болон*
- *Статистик, мэдээлэл цуглуулах ажилтан: ОУИТБС-ын мэдээллийн санг бүрдүүлэх, байнга шинэчлэх (Үр дүн 8.7 дээр үзнэ үү) үүргийн хүлээх ба аудитын нэгтгэл хийх үйл ажиллагааны үеэр компаниуд болон төрийн байгууллагуудтай харилцах гол хүн байх юм.*

8.9 Аудитын нэгтгэлийн цаг хугацаа

Аудитын нэгтгэлийн үйл ажиллагаа 2013 оны 7 дугаар сараас эхлэн явагдсан. Тайлан гаргагч байгууллагуудын ажилтнуудын ихэнх нь тухайн үеэр амралттай байсан тул мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байлаа. Зуны улиралд мөн компаниудын уул уурхайн үйл ажиллагааны гол үе байсан тул ихэнх нь бүрэн хүчин чадлаараа ажлаа явуулж, ихээхэн ачаалалтай байжээ.

Энэхүү нөхцөл байдал нь ихээхэн хугацаа алдахад хүргэж, холбогдох хүмүүстэй харилцах, нягтлан бодогч нартай холбоо тогтоон тодруулга авахад хүндрэл үүсгэж байлаа.

Цаашид аудитын нэгтгэл хийх хугацааг сайтар төлөвлөн амралтын болон ажлын ид ачааллын үетэй давхцуулахгүй байхыг зөвлөмж болгож байна. Ингэснээр тайлан гаргагч аж ахуйн нэгж, байгууллагууд илүү үр дүнтэй хамтран ажиллаж, аудиторуудад туслах боломжтой болох юм.

8.10 Урьд жилүүдийн нэгтгэлээс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт дутмаг

Дээр дурдсан ихэнх асуудал болон зөвлөмжүүдийг урьд жилүүдийн ОУИТБС-ын тайлангуудад дурдаж байжээ. Энэ жилийн нэгтгэлээр ч өмнө өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй болох нь харагдаж байна. Хэрэв өмнөх жилүүдийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн бол аудитын нэгтгэл хийх үеэр гарч ирсэн олон тооны асуудлуудаас зайлсхийх боломжтой байв.

Тулгараад байгаа сул талуудыг шийдэх, өмнөх жилүүдийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө байхгүй байгаа нь ОУИТБС-ын тайланг бэлтгэн нийтлэхэд саад учруулах магадлалтай юм. Энэ нь мөн нэгтгэлийн ажлыг хүндрүүлж чухал боловч шийдэгдээгүй зөрүүг нэмэгдүүлж болно.

Ауитын нэгтгэл хийгдсэний дараагаар Ажлын хэсэг нь ОУИТБС-ын тайланд тусгагдсан сул талууд, олж илрүүлсэн зүйлс дээр анхаарал хандуулан, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай. Ажлын хэсэг нь өөрийн гишүүдэд (компани, төрийн байгууллагууд болон иргэний нийгэм) үүрэг өгч, тухайн асуудлуудаас хамааран арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Тухайн үүрэг хүлээсэн Ажлын хэсгийн гишүүн нь Ажлын албатай хамтран ажиллаж, тухайн асуудлуудад хандан үйл ажиллагаа явуулан дараа дараагийн нэгтгэлийн үед хэрэглэх шийдлүүдийг санал болгох нь зүйтэй.

Түүнчлэн бидний зүгээс Ажлын хэсэг нь дараа дараагийн хурлын хэлэлцэх асуудалд ОУИТБС-ын тайлангаар гарсан асуудлуудад арга хэмжээ авах асуудлыг оруулан хэлэлцэн, арга хэмжээ авахыг зөвлөмж болгож байна

Хавсралт

Хавсралт 1: Шийдэгдээгүй эцсийн зөрүү

Но.	Компани нэр	Компаниуд (мянган төгрөг)	Засгийн газар (мянган төгрөг)	Зөрүү (мянган төгрөг)
1	Авдарбаян ХХК	81,241	81,241	-
2	АГМ майнинг ХХК	259,972	307,972	(48,000)
3	Адамас майнинг ХХК	107,453	107,453	-
4	Адил оч ХХК	194,446	194,511	(65)
5	Адуунчулуун ХК	863,982	863,979	3
6	Азиагоулд Монголиа ХХК	227,863	222,857	5,006
7	Алтайн хүдэр ХХК	22,754,141	22,428,073	326,068
8	Алтан дорнод монгол ХХК	9,762,567	9,762,567	-
9	Алтанрио монголиа ХХК	259,676	259,834	(158)
10	Анд Сөүрвэй ХХК	131,808	131,862	(54)
11	Андын-Илч ХХК	2,562,090	2,560,172	1,918
12	Аниан Ресорсиз ХХК	140,016	134,166	5,850
13	Анхай Интернэшнл ХХК	3,050,049	3,036,426	13,623
14	АУМ ХХК	2,002,445	2,004,035	(1,590)
15	Багануур ХК	8,430,402	8,430,470	(68)
16	Бадмаараг хаш ХХК	408,539	408,539	-
17	Батумайнинг Монгол ХХК	210,673	198,623	12,050
18	Баялаг-Орд ХХК	213,455	158,512	54,943
19	Баян эрч ХХК	2,175,395	2,175,492	(97)
20	Баян-Айраг Эксплорэйшн ХХК	2,375,038	2,475,423	(100,385)
21	Баянтэгш Импекс ХХК	146,623	142,945	3,678
22	Баянтээг ХК	262,013	262,013	-
